

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

1992-2003 ОНД БАТЛАГДСАН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛД ХИЙСЭН СУДАЛГАА

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТ 2004 ОН

**1992-2003 ОНЫ ХООРОНД БАТЛАГДАН ХУЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛЖ
БУЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫГ СУДАЛЖ, ДҮН ШИНЖИЛГЭЭ
ГАРГАСАН СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

1. Академич Ж.Амарсанаа - Судалгааны багийн зөвлөх
2. Доктор Б.Алтангэрэл - Судалгааны багийн ахлагч

Судалгааны багийн гишүүн:

3. С.Должин - ХЗҮТ, ОУЭЗС
4. Ц.Одгэрэл - ХЗҮТ, КСС
5. Э.Ганчимэг - ХЗҮТ, ИХТС
6. Д.Оросоо - ХЗҮТ, ТБХТС
7. Б.Амарсанаа - ФСЭХ
8. Э.Байгаль - МУИС, ХЗС
9. М.Мөнхбат - МУИС, ХЗС
10. М.Уянга - МУИС, ХЗС
11. В.Оюумаа - МУИС, ХЗС
12. Э.Ганболд - УИХТГ
13. Г.Зина - ХЗДХЯ
14. Х.Гэрэлчулуун - ХЗДХЯ
15. Б.Гүнбилэг - ХЗҮТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**1992-2003 ОНД БАТЛАГДСАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ
СУДАЛЖ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГААНЫ
МАТЕРИАЛЫН ТОВЪЁОГ**

Агуулга	Хуудасны дугаар
Удирдамж	
1. Судалгааны тайлан	1-2
2. 1992-2003 онд батлагдсан Засгийн газрын тогтоол судалсан тухай нэгдсэн хүснэгт /хавсралт-1/	3-5
3. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээний хүний эрхийн холбогдолтой заалтыг зөрчсөн гэж үзэж буй Засгийн газрын тогтоолын жагсаалт /хавсралт-2/	6-12
4. 1992-2003 онд батлагдан одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хүний эрхтэй холбоотой тогтоолыг жагсаалт /хавсралт-3/	13-24
5. Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлд тусгах санал /хавсралт-4/	25-26
6. Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал /хавсралт-5/	27
7. Засгийн газрын тогтоол боловсруулж буй албан тушаалтанд зориулсан сургалтын хөтөлбөр /хавсралт-6/	28
8. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээний хүний эрхийн холбогдолтой заалтыг зөрчсөн гэж үзэж буй Засгийн газрын тогтоолын хэм хэмжээг тайлбарлахад ашигласан хуулийн холбогдох зүйл, хэсэг /хавсралт-7/	29-35
9. Судалгаанд ашигласан Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн холбогдолтой олон улсын гэрээ /хавсралт-8/	36-37
10. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээний хүний эрхийн холбогдолтой заалтыг зөрчсөн гэж үзэж буй Засгийн газрын тогтоолын хуулбар /хавсралт-9/	38

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛД ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛААР
СУДЛАГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2003.11.24

ЗОРИЛТ

- Засгийн газрын тогтоолын заалт нь:
1/ Монгол Улсын олон улсын гэрээ;
2/ Монгол Улсын Үндсэн хууль;
3/ Хуульд заасан;
• хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаархи заалтад хэрхэн нийцэж буйд дүн шинжилгээ хийх.
Засгийн газрын тогтоолын хүний эрхийн талаархи хэм хэмжээг зөрчсөн заалтыг хүчингүй болгох, өөрчлөх тухай дүгнэлт, саналын төслийг бэлтгэх.

ХУГАЦАА

- Судлагааны ажлыг 2 үе шаттай зохион байгуулна.
1. Судлагаа хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах ажлыг 2003 оны 11 дүгээр сарын 25-наас 2003 оны 12 дугаар сарын 28-нд хийнэ.
2. Сургалт, семинар-ярилцлагыг 2004 оны 1, 2 дугаар сард зохион байгуулна.

ОРОЛЦОХ

- Судлагаа хийх, сургалт, семинар-ярилцлага зохион байгуулах ажилд ХЗҮТ, ШУА-ийн ФСЭХ-ийн ХЗСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд, МУИС-ийн ХЗС-ийн ОУЭЗ-н тэнхимийн багш нар оролцоно.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Засгийн газраас батласан одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа тогтоолыг нэг бүрчилэн уншин судалж хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой тогтоол, тогтоолын заалтыг ангилан түүвэрлэж дүгнэлт хийх;
- Засгийн газрын тогтоолыг боловсруулан гаргахад оролцдог зарим хүнтэй уулзаж санал солилцох;
- Засгийн газрын тогтоолыг боловсруулан гаргах үе шатанд ажилладаг албан тушаалтанд хүргүүлэх зөвлөмжийн төслийг боловсруулах.

ҮР ДҮН

- Засгийн газрын тогтоол, тогтоолын заалт нь Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хууль, хуулийн заалттай хэрхэн нийцэж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Засгийн газрын тогтоол, тогтоолын заалт нь олон улсын гэрээ, Үндсэн хууль, хуулийн заалттай илт зөрчилдсөн тохиолдолд

УИИМН
СУДАЛГААНЫ САН

- тэдгээрийн заалтыг хүчингүй болгох санал, зөвлөмж боловсруулж Хүний Эрхийн Үндэсний Комисст илгээх;
- Уг асуудлаар Хүний Эрхийн Үндэсний Комиссын 2004 оны хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэлд тусгах дүгнэлт, зөвлөмжийг бэлтгэж хүргүүлэх;
 - Засгийн газрын тогтоолыг боловсруулж буй албан тушаалтанд зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Хүний Эрхийн Үндэсний Комисстой хамтран сургалт зохион байгуулах;
 - Холбогдох байгууллагуудтай хамтран Хууль Зүйн Үндэсний Төвд семинар-ярилцлага зохион байгуулах.

Report on Study and Investigation on the Government Resolutions enacted between 1992-2003

“ “ February 2004

Ulaanbaatar

During the period of November, 2003 – February, 2004 a research team consisting of 15 lecturers and researchers of the National Legal Centre, the Legal Research Centre of the Institute on Philosophy, Sociology and Law of the Academy of Sciences of Mongolia and International Law Department of the Legal School of the National University of Mongolia has undertaken study and investigation on the resolutions of the Government of Mongolia enacted between 1992-2003.

The main purpose of the study and investigation was the ascertaining how the Government Resolutions conform to the provisions and norms of the Constitution, laws of Mongolia and international human rights treaties to which Mongolia is a party.

First of all, team members undertook research on 39 international human rights treaties to which Mongolia is a party and concerned mongolian laws including the Constitution of Mongolia. Then the team started to study and investigate the Government Resolutions enacted between 1992-2003 at the Law Fund of the Ministry of Justice and Interior of Mongolia.

There are 2390 valid Government Resolutions from the 2838 Government Resolutions enacted between 1992-2003. The team discovered 108 of them have a connection with human rights /see appendix 3 of the Report/. Most of the 108 resolutions appear connected with social and cultural human rights.

During the study and investigation, more attention has been paid on whether the Government Resolutions are in conformity with the provisions concerning the protection of human rights and freedom regulated by the Constitution, laws of Mongolia and international human rights treaties, and in the most of the resolutions such violations have not been occurred. Although 5 resolutions amongst the above-mentioned Government Resolutions have been found as breaching the Constitution, laws of Mongolia and the international human rights treaties to which Mongolia is a party. Each of the above 5 resolutions has been analysed as follows. For instance, in comparison with the relevant resources a complete investigation list has been made on:

1. what is stated in the relevant resolution,
2. which article of the Constitution of Mongolia is breached,
3. which article and provision of which law of Mongolia is breached,
4. which provision of which international human rights treaty to which Mongolia is a party is breached /see appendix 2 of the Report/.

On the basis of the study and investigation on the above-mentioned 5 resolutions the team has suggested proposal and recommendation on making amendments to the relevant resolutions and as well as prepared some proposals for a possible inclusion of them to the 2004 report of the National Human Rights Commission of Mongolia /see appendix 4 and appendix 5 of the Report/.

Beside this a plan on organising a seminar addressed to the officials developing Government Resolutions has been proposed /see appendix 6/.


CONCLUSIONS:

It was the first time study and investigation on whether the Resolutions of the Government of Mongolia enacted in 1992-2003 are in conformity with the provisions and norms of the Constitution, laws of Mongolia and the international human rights treaties to which Mongolia is a party.

Draft Resolutions sent from the ministries and agencies for the consideration of the Government or developed by the Secretariat of the Government of Mongolia are reviewed on a high professional level by the Legal Department of the Secretariat of the Government of Mongolia, therefore only a few number of the resolutions breaching the Constitution and laws of Mongolia and the international treaties have been discovered during our study as stated.

Although, the above statement does not mean that the Government of Mongolia enacts resolutions and decisions completely conforming to the Constitution and laws of Mongolia and the international human rights treaties. Because according to some study and investigation results there are still many provisions breaching the Constitution and laws of Mongolia and international human rights treaties in the decrees and other decisions enacted namely by the Ministries and agencies of the Government of Mongolia. It should be an object of another study and investigation and in this way there will be an opportunity to undertake a complete analysis and conclusion on whether the Government resolutions and decisions are in conformity with the Constitution and laws of Mongolia and the international treaties.

HEAD OF THE PROJECT GROUP



ALTANGEREL B.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1992-2003 ОНЫ ХООРОНД ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН ТОГТООЛЫГ СУДАЛЖ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАЙЛАН

2004 оны 1 дүгээр
сарын "... " -ы өдөр

Улаанбаатар хот

Хууль зүйн үндэсний төв, Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төв, Монгол улсын их сургуулийн Хууль Зүйн Сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, ажилтан нараас бүрдсэн 15 хүнтэй судалгааны багаас 2003 оны 11, 12 дугаар сар, 2004 оны 1, 2 дугаар сард 1992 оноос хойш батлагдан хүчин төгөлдөр үйлчилж буй Засгийн газрын тогтоолд судалгаа, дүн шинжилгээ хийлээ.

Судалгаа, дүн шинжилгээний гол зорилго нь Засгийн газрын тогтоолууд Монгол Улсын олон улсын гэрээний заалттай, хэм хэмжээтэй хэрхэн нийцэж байгааг тогтооход чиглэв.

Багийн гишүүд Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн холбогдолтой 39 гэрээ болон 1992 оноос хойш батлагдан одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Засгийн газрын тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль тогтоомжийн санд судаллаа.

1992-2003 онд нийт 2838 тогтоол батлагдсанаас одоо хүчин төгөлдөр үйлчилж буй тогтоол 2390 байна. Үүнээс хүний эрхтэй холбоотой тогтоол 108 байна гэж үзлээ. /Хавсралт-3-ыг үзнэ үү/ Эдгээр нь ихэвчлэн хүний нийгэм, соёлын эрхтэй холбоотой байгаа нь харагдаж байна.

Судалгааны явцад Засгийн газрын тогтоол нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах заалттай нийцэж буй эсэхэд илүү анхаарч ажилласан бөгөөд ихэнхи оны тогтоолд ийм зөрчил илрээгүй болно. Дурдсан 12 оны Засгийн газрын тогтоолоос Монгол Улсын Үндсэн хууль, хууль, нэгдэн орсон хүний эрхийн холбогдолтой олон улсын гэрээ зөрчсөн гэж үзсэн нийт 5 тогтоол байна гэж үзлээ. Эдгээр 5 тогтоол тус бүрт дараахь байдлаар нарийвчилсан дүн шинжилгээ хийлээ. Тухайлбал:

1. Уг тогтоолд юу гэж заасан,
2. Монгол Улсын Үндсэн хуулийн ямар зүйлтэй зөрчилдсөн,
3. Монгол Улсын ямар хуулийн ямар зүйл, хэсэгтэй зөрчилдсөн,
4. Монгол Улс нэгдэн орсон ямар олон улсын гэрээний ямар заалт зөрчсөн талаар бодит эх сурвалжтай нь харьцуулан дэлгэрэнгүй жагсаалт гаргав. /Хавсралт-2-ыг үзнэ үү/

Дурдсан 5 тогтоол болон хүний эрхийн холбогдолтой гэж үзсэн бусад тогтоолд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дурдсан тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон цаашид анхаарах зарим асуудлын талаар 2004 оны ХЭҮК-ын илтгэлд оруулах санал, зөвлөмж болосруулж ХЭҮК-т илгээлээ. /Хавсралт-4-өөс үзнэ үү/

Мөн Засгийн газрын тогтоол боловсруулж буй албан тушаалтанд зориулсан сургалт-семинар зохион байгуулах төлөвлөгөө гаргалаа. /Хавсралт-6-г үзнэ үү/

ДҮГНЭЛТ:

Монгол Улсын Засгийн газрын тогтоол Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээний заалт, хэм хэмжээтэй хэрхэн нийцэж буйд 1992-2003 онд батлагдсан тогтоолд анх удаа судалгаа явуулж, дүн шинжилгээ хийв.

Яам, агентлагаас өргөн мэдүүлсэн болон Засгийн газрын хэрэг эрхлэх газраас боловсруулсан тогтоолын төслийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хуулийн хэлтэс мэргэжлийн харьцангуй өндөр түвшинд хянадаг тул Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээг зөрчсөн тогтоол тооны хувьд бага байна.

Гэвч энэ нь Монгол Улсын Засгийн газар тогтоол, шийдвэрээ Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээний заалтад бүрэн нийцүүлэн гаргаж байна гэсэн үг хараахан биш юм. Учир нь Засгийн газрын харьяа яам, агентлагаас гаргаж буй тушаал, бусад шийдвэрт Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээ зөрчсөн заалт нэлээд байгаа нь зарим судалгааны үр дүнгээс харагдаж байгаа. Энэ нь өөр нэг судалгааны объект болох ёстой бөгөөд тэгж баймааж Засгийн газрын тогтоол, шийдвэр, Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээний заалттай хэрхэн нийцэж буй талаар иж бүрэн дүн шинжилгээ, дүгнэлт хийх бололцоо бүрдэнэ гэж үзэж байна.

ТӨСЛИЙН БАГИЙН АХЛАГЧ

Б.АЛТАНГЭРЭЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


1992-2003 ОНД БАТЛАГДСАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ СУДАЛСАН ТУХАЙ НЭГДСЭН ХҮСНЭГТ

Д/д	Он	Нийт тогтоолын тоо	Хүчингүй болсон тогтоолын тоо	Хүний эрхтэй холбоотой тогтоолын тоо	Зөрчигдсөн гэж үзэж буй тогтоолын тоо	Одоо хүчинтэй үйлчилж байгаа бөгөөд хүний эрх зөрчсөн гэж буй тогтоолын дугаар, нэр, агуулга
1	1992	87	34	2	-	-
2	1993	199	63	1	-	-
3	1994	234	53	10	-	-
4	1995	243	50	6	-	-
5	1996	333	68	2	-	-
6	1997	258		8	1	Дугаар 107. Ой хээрийн түймрийн үед хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах журам батлах тухай журам батлах тухай
7	1998	240	49	9	-	-
8	1999	229	39	28	-	-
9	2000	204	39	13	2	1. Дугаар 33. 2000 онд цэргийн албыг дүйцүүлэн хаалгах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2. Дугаар 96. Журам шинэчлэн батлах тухай Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж огох, эргэж төлүүлэх журам
10	2001	289	43	11	1	1. Дугаар 61. 2001 онд цэргийн албыг дүйцүүлэн хаалгах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай
11	2002	275	5	7	-	-
12	2003	247	5	11	1	Дугаар 13. Дүрэм батлах тухай Гаалийн улсын байцаагчийн сахилгын тусгай дүрэм
Бүгд	12 он	2838	448	108	5	

1992-2003 онд батлагдсан Засгийн Газрын (хүний эрхийн холбогдолтой тогтоолын график үзүүлэлт)



1992-2003 онд батлагдсан Засгийн Газрын (хүний эрх зөрчигдсөн гэж үзэж буй тогтоолын график үзүүлэлт)



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, ХУУЛЬ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ХҮНИЙ ЭРХИЙН ХОЛБОГДОЛТОЙ
ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ГЭЖ ҮЗЭЖ БУЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**

Д/д	Засгийн газрын тогтоолын нэр, дугаар, он сар өдөр	Тогтоолын заалтын агуулга	Зөрчсөн гэж үзсэн хэм хэмжээ
1	1997.4.30 Дугаар 107 Журам, жагсаалт батлах тухай	1. Ой, хээрийн түймрийн үед хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах журам 2. Ой, хээрийн түймрийг унтраах ажилд оролцож буй иргэдийн хангамж, тэдгээрийн заавал эзэмшсэн байх зүйлийн жагсаалт	<p>Нэг. Уг журмын 21 дүгээр зүйлд “Ой хээрийн түймэрт дайчилгаагаар ажилласан иргэний эрхэлж байсан ажил, албан тушаалыг үндсэн аж ахуйн нэгж, байгууллага хэвээр хадгалж дундаж цалинг олгоно” гэсэн нь:</p> <p>1. Үндсэн хуулийн 16.3-ыг зөрчсөн гэж үзэх үндэслэл: “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэсэнтэй зөрчилдсөн гэж үзсэн.</p> <p>Хоёр. Уг журмын 16 дугаар зүйлд “түймэр унтраах ажилд Монгол Улсын харьяат, хөдөлмөрийн чадвартай, 16-60 хүртэл насны эрэгтэй, 16-55 хүртэл насны эмэгтэй иргэдийг дайчлан оролцуулна. Жирэмсэн эмэгтэй, асрамжлах хүнгүй сургуулийн өмнөх насны хүүхдийн асран хамгаалагч, эмнэлэг, эрчим хүч, холбооны байгууллагын ээлжийн ажилчид, холбогдох хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр дайчлахыг хориглосон хүмүүст энэ заалт хамаарахгүй” гэсэн нь:</p> <p>1. Хүүхдийн эрхийн конвенц 1 дүгээр зүйл, 6.2-ыг зөрчсөн гэж үзэх үндэслэл:</p>

--	--	--

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 1 дүгээр зүйлийн “Тухайн хүүхдэд үйлчлэх хуулийн дагуу үүнээс эрт насанд хүрсэн гэж тооцохгүй бол энэхүү Конвенцийн зорилго ёсоор 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэсэнтэй,

6.2-т заасан “оролцогч улсууд хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих нөхцөл бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана” гэсэнтэй зөрчилдаж байна гэж үзсэн байна.

2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7.6-г зөрчсөн гэж үзэх үндэслэл:

“Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүүхдээр ёс суртахуун, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, тэдний хөдөлмөрийн хөлсийг шударга бусаар тооцож олгох, гуйлга гуйлгах, хууль бусаар нэрээр нь ашиг олох үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэнтэй зөрчилдөж байна гэж үзсэн.

3. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3.1-т “Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ” гэсэн нь 16 настай эмэгтэй, эрэгтэй хүнийг хүүхэд гэж үзэх үндэслэл болж байна.

2	2000.2.23 Дугаар 33. 2000 онд цэргийн албыг дүйцүүлэн хаалгах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай	Аймаг тус бүрт, нийслэлд өөр өөр хязгаар тогтоосон байна. Жишээлбэл: Архангай 60, Увс 52, Дархан 16 гэх мэт
---	--	---

2000 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг аймаг, нийслэлд өөр өөр тогтоож, хязгаарласан нь:

1. Эдийн засаг, нийгэм, соёлын тухай олон улсын пакт зөрчсөн гэж үзэх үндэслэл:

Пактын 2.2-ийн “Энэхүү Пактад оролцогч улсууд арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар үл ялгаварлан энэхүү Пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг хангана” гэсэнтэй,

Пактын 3 дугаар зүйлийн “Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд адил тэгш эдлүүлэх үүрэгтэй” гэсэнтэй,

2. Үндсэн хуулийн 16.11-ийг зөрчсөн гэж үзэх үндэслэл:

Уг зүйлд “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” гэж заасантай,

3. Үндсэн хуулийн 16.18-ыг зөрчсөн гэж үзэх үндэслэл:

Уг зүйлд “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэсэнтэй зөрчилдсөн гэж үзсэн.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

	<p>2000.6.21 Дугаар 96. Журам шинэчлэн батлах тухай</p>	<p>Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж өгөх, эргэж төлүүлэх журам</p>	<p>Журмын 31-д “Энэхүү журмын 28-д зааснаас бусад шалтгаанаар суралцагч цаашид суралцахгүй болсон тохиолдолд сургалтын төлбөрийн зээл, тусламж, тэтгэлгийг зогсоож суралцахгүй болсон тухайн сараас эхлэн жилийн 3 хувийн хүүтэйгээр 2 жилийн дотор буцааж төлүүлнэ. Хүүгээс хүү тооцохгүй.” гэж заасан нь:</p> <p>1. Эдийн засаг, нийгэм, соёлын тухай олон улсын пактын 13.1-ийн в, д-г зөрчсөн гэж үзэх үндэслэл: в-д “боловсролыг аажмаар үнэ төлбөргүй олгох болон зохих бүхий л арга хэрэгслээр авьяас чадварыг нь харгалзан дээд боловсролыг бүх хүнд хүртээх” гэсэнтэй, д-д “бүх шатны сургуулийн тогтолцоог эрчимтэй хөгжүүлэх, хангалттай тэтгэлэг олгох тогтолцоо бий болгох” гэсэнтэй,</p> <p>2. Үндсэн хуулийн 16.14-ийг зөрчсөн гэж үзэх үндэслэл: Уг зүйлд “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” гэсэнтэй,</p> <p>3. Иргэний хуулийн “Гэрээний стандарт нөхцөл” гэсэн 3 дугаар дэд бүлгийн 202.2.5-ыг зөрчсөн гэж үзэх үндэслэл: Уг зүйлийн “гаргасан зардлыг хэт өндрөөр буюу нэмэгдүүлэн тооцож шаардах эрхийг өөртөө олгосон” гэсэн нь тухайн стандарт гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохоор заасантай,</p> <p>4. Иргэний хуулийн 202.2.15-ыг зөрчсөн гэж үзэх үндэслэл: Уг зүйлийн “санал гаргагч тал хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс нөгөө тал гэрээг цуцалсан бол санал гаргагч талд анз төлөхөөр заасан” стандарт гэрээ хүчин төгөлдөр бус байхаар хуульчилсан байгаатай зөрчилдөж байна.</p>
--	---	--	---

3			
4	<p>2001.3.28 Дугаар 61. Тооны дээд хязгаар тогтоох тухай</p>	<p>Цэргийн албыг 2001 онд биеэр дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг хавсралтаар баталсан байна</p>	<p>2001 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг аймаг, нийслэлд өөр өөр тогтоож, хязгаарласан нь: 1. Эдийн засаг, нийгэм, соёлын тухай олон улсын пакт зөрчсөн гэж үзэх үндэслэл: 2.2-ийн “Энэхүү Пактад оролцогч улсууд арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар үл ялгаварлан энэхүү Пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг хангана” гэсэнтэй, 3 дугаар зүйлийн “Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд адил тэгш эдлүүлэх үүрэгтэй” гэсэнтэй, 2. Үндсэн хуулийн 16.11-ийг зөрчсөн гэж үзэх үндэслэл: Уг зүйлд “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” гэсэнтэй, 3. Үндсэн хуулийн 16.18-ийг зөрчсөн гэж үзэх үндэслэл: Уг зүйлд “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэсэнтэй зөрчилдсөн гэж үзсэн байна.</p>

5	<p>2003.1.22 Дугаар 13. Дүрэм батлах тухай Гаалийн улсын байцаагчийн сахилгын тусгай дүрэм</p>	<p>Дүрмийн 6.2-т “сахилгын шийтгэл ноогдуулах нь түүнийг дахин гаалийн албанд авахаас татгалзах үндэслэл болно” гэжээ</p> <p>UIH.MN СУДАЛГААНЫ САН</p>
---	--	--

Дүрмийн 3.1-д “Улсын болон хувийн эрх ашиг зөрчилдөж болох аливаа нөхцөл байдалд орохоос цаг ямагт өөрийгөө сэргийлж, хууль тогтоомжид хориглохоор заасан болон дараахь үйлдэл гаргахыг хориглоно” гэсэн бөгөөд,

3.1.3-т “гаалийн хяналт, шалгалт, бүрдүүлэлтийг хийсний төлөө үйлчлүүлэгч байгууллага, иргэнээс барааг нь үнэгүй авах, хөнгөлөлттэй үнээр худалдан авах, үйлчлүүлэх, зээл, бэлэг дурсгалын зүйлс авах, өгөх, зуучлах, дэмжих, зөвлөх, тэдний зардлаар гадаад, дотоодод зорчих, байрлах, **хоол, цайллаганд уригдах** зэрэг хууль бус хангамж эдлэх”;

5.2. Хууль тогтоомж болон энэ дүрмийн **Гурвын 1-д хориглохоор заасныг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл нь гаалийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.**

6.2-т “Байцаагчид гаалийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулах нь төрийн албанаас чөлөөлөх, гаалийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэсэн нь:

1. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенцийн 1.1.б-ыг зөрчсөн гэж үзэх үндэслэл:

Уг зүйлд ялгаварлан гадуурхах байдал гэсэн нэр томъёонд “ажил олгогч, ажилчид, тэдгээрийг төлөөлөх байгууллагууд болон холбогдох бусад байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр гишүүн улсад тогтоосон ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт адил тэгш боломж, хандлагыг үгүйсгэх буюу зөрчихөд хүргэж байгаа аливаа ялгаварлах, хасан гадуурхах, давуу байдал олгох үйлдэл”-ийг оруулсантай,

СИМН
СУДАЛГААНЫ САН

**1992-2003 ОНД БАТЛАГДАН ОДОО ХҮЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛЖ БУЙ
ХҮНИЙ ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**

	Батлагдсан он сар өдөр, дугаар	Тогтоолын нэр	Агуулга	Бусад /хүний эрхийн аль бүлд хамаарах/
1.	1992.9.28, № 34	Чөлөөт үнийн тогтолцоонд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай	Монополь өндөр үнэ тогтоон хэрэглэгчдийн эрх ашгийг хохироох явдлыг гаргуулахгүй байх зорилгоор үнийн үндэслэлд хяналт тавих	Эдийн засгийн эрх
2.	1992.11.13, №57	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад баримтлах зарчимыг дэмжих тухай	НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс 1985 онд сайшаасан хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад баримтлах зарчимыг дэмжих	Нийгэм соёлын эрх
3.	1993.11.18, №166	НҮБ-ын үйлдвэр хөгжлийн байгууллага /ЮНИДО/-ын Монголын үндэсний хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	НҮБ-ын үйлдвэр хөгжлийн байгууллагын Монголын үндэсний хорооны дүрэм	Эдийн засаг, нийгэм соёлын эрх
4.	1994.8.24, №151	Хорих байгууллагын талаар авах арга хэмжээний тухай	Дарьт дахь хорих ангийг чанга дэглэмтэй хорих анги болгон зохион байгуулж цагдан хоригдогсдыг хорих байгууллагын харьяа нэгдсэн эмнэлэгт эмчлэх журам гаргаж мөрдөх тухай	Нийгэм соёлын эрх
5.	1994.9.28, №169	Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны цалингын тухай	Дипломат төлөөлөгчийн газарт ажиллахаар томилогдсон хүн бэлтгэл хийх, буцаж ирээд томилолт хүлээх, түүнчлэн анх явж очих болон бүрмөсөн буцаж ирэх хугацаанд ногдох хөдөлмөрийн хөлсийг бодож олгохдоо МУ-ын холбогдох байгууллагын адилтгах албан тушаалын хөдөлмөрийн үндсэн хөлсний хэмжээг баримтлана гэжээ	Нийгэм соёлын эрх
6.	1994.9.28, №171	Нийгмийн даатгалын тухай	Нийгмийн даатгалын байгууллага,	Нийгэм соёлын

		хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай	байцаагчийн дүрэм, нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм	эрх
7.	1994.10.6, №175	Журам батлах тухай	Архинд донтох өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх байгууллагуудын ажиллах журам	Нийгэм соёлын эрх
8.	1994.11.30, №192	Үнэт цаасны хорооны орон тоо, сарын цалингийн санг батлах тухай	Үнэт цаасны хорооны ажлын албаны орон тоо, сарын цалингийн дээд хязгаар, жилийн зардлын төсөв, ажлын байр, унаа, аж ахуй, бичиг хэргийн үйлчилгээгээр хангах тухай	Нийгэм соёлын эрх
9.	1994.12.15, №205	Тэтгэвэр авагчдын нэмэгдэл нөхвөрийн тухай	МУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 1995 оны үндсэн чиглэлд заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 1995 оноос өмнө өндөр насны, тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон иргэдэд тэтгэвэр, ЗГ-ын тогтоолоор хэмжээг нь тогтоон олгож байгаа нөхвөр дээр нь тэдгээрийн нийлбэр дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нөхвөр олгох тухай	Эдийн засгийн эрх
10.	1994.12.21, №211	Төсөвт байгууллагын ажилтны хөдөлмөрийн хөлсний хэмжээг нэмэгдүүлэх тухай	25 хувиар нэмэгдүүлэх тухай	Нийгэм соёлын эрх
11.	1994.12.21, №212	Журам батлах тухай	Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дундажийг тодорхойлох тухай	Нийгэм соёлын эрх
12.	1994.12.28, №230	Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай	Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд ядуурлыг бууруулах зөвлөлийн нарийн бичгийн даргын цалин, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, ядуурлыг бууруулах нэгдсэн сан байгуулах тухай	Нийгэм соёлын эрх
13.	1994.12.28, №232	Хүн амаас авч буй хураамж, төлбөртэй холбогдуулан авах арга хэмжээний тухай	Хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө	Нийгэм соёлын эрх

			авч байгаа хураамж болон торгуулийн орлогыг зөвхөн төсвөөр дамжуулан зарцуулах тухай Аж ахуйн нэгж байгууллагаас хүн амд үзүүлэх нийтлэг үйлчилгээний үнэ, хөлсийг үнийн зөвшлийн комист оруулан, шударга бус үнэ тогтоон дангаар ноёрхох болон давамгайлах байдал олж авах аливаа илрэлийг таслан зогсоох тухай	
14.	1995.4.19, №55	Суурь боловсрол эзэмшээгүй иргэдийн сургалтын талаар авах арга хэмжээний тухай		
15.	1995.5.2, №59	Тэтгэврийг хөнгөлттэй тогтоох хөдөлмөрийн нөхцлийн тухай	Хөдөлмөрийн стандарт болон хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт, судалгааны ажлын үр дүнг харгалзан тэтгэврийг хөнгөлттэй тогтоох, газрын доор болон хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийг тогтоон холбогдох жагсаалтыг батлах	Нийгэм соёлын эрх
16.	1995.5.2, №60	Төрийн албаны хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон авах арга хэмжээний тухай		Нийгэм соёлын эрх
17.	1995.5.10, №65	Ахмад дайчдад буцалтгүй тусламж олгох тухай		Нийгэм соёлын эрх
18.	1995.5.24, №79	Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон зарим арга хэмжээний тухай	Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй, орон гэргүй, тэнэмэл, ядуу хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлэх тухай	Нийгэм соёлын эрх
19.	1995.6.14, №95	Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн албан тушаалын сүлжээг батлах тухай		Нийгэм соёлын эрх
20.	1996.1.31, №23	Хорих байгууллагаудад нийт бие бүрэлдэхүүний сахилга, харуул хамгаалалтын ажлыг сайжруулах тухай		Нийгэм соёлын эрх

21.	1996.4.25, №91	Захиргааны журмаар албадан саатуулах байрны дэглэм журам, хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах байрны дэглэм журам		Нийгэм соёлын эрх
22.	1997.9.22, №193	Өнчин, эцэг эхийн хараа хяналтаас гарсан хүүхдийн талаар авах арга хэмжээний тухай	Өнчин, эцэх эхийн хараа хяналтаас гарсан хүүхдийн талаар зохиох үйл ажиллагааны чиглэлийг батлан, шаардагдах хөрөнгийг улсын төвлөрсөн төсөвт тусгах, хүүхэд гэр орондоо өсч хүмүүжих нөхцөлийг бүүрдүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах, зохих шатны боловсрол олгох, гэр бүлийг нь дэмжих, шаардлагатай тохиолдолд халамжийн үйлчилгээнд хамруулах замаар хүүхэд тэнэмэл болохоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах тухай	Нийгэм соёлын эрх
23.	1997.10.22, №212	Худалдааны албан татвараас чөлөөлөх тухай	Алт олборлолтыг жилээс жилд нэмэгдүүлж, барилгын материалын үйлдвэрлэл, барилга, угсралт, зам барилгын салбарт ихээхэн хэмжээний хөрөнгө оруулж байгааг харгалзан “Эрэл” ХХК-ны 1994-1996 онуудад олборлосон алтанд ногдуулсан 588 сая төгрөгийн худалдааны албан татварын 50 хувийг чөлөөлөх тухай	Эдийн засгийн эрх
24.	1997.12.24, №254	1998 оныг “Залуучуудын жил болгох тухай”	Улс орны хөгжил, нийгмийн амьдралд залуучуудын оролцох оролцоог идэвхижүүлэх зорилгоор 1998 оныг “Залуучууддын жил” болгох, зохион байгуулах ажлын чиглэлийн тухай	Нийгэм соёлын эрх
25.	1997.12.24, №257	Хөтөлбөр батлах тухай	1997 онд хийсэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн түвшин тогтоох улсын үзлэгийн дүнд тулнуурлан	Нийгэм соёлын эрх

			“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг батлаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах тухай	
26.	1997.5.7, №116	Үндэсний хөтөлбөр байгуулж, төв батлах тухай	Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлах тухай	Нийгэм соёлын эрх
27.	1997.2.4, №37	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийг 1997.1.1-ээс эхлэн Нийслэлийн ЗД-ын мэдэлд шилжүүлэн, тус үйлдвэрийн 1996 оны алдагдлыг нөхөөд зориулж 12 сая төгрөгийг гаргах, үйлдвэрийн цахилгаан, дулаан, ус, уурын зардлын 50 хүртэл хувийг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх тухай	Нийгэм соёлын эрх
28.	1997.2.19, №48	Гааль, худалдааны албан татварыг бууруулах, чөлөөлөх тухай	Гурилын хангамжийг сайжруулах зорилгоор 1997.2.19-ээс 8 сарын 30 хүртэл хугацаанд импортын гурил, үрийн болон таваарын буудайн гаалийн татварыг 50 хувиар бууруулах тухай	Эдийн засгийн эрх
29.	1997.2.19, №55	Амьжиргааны доод түвшингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Өрхийн ам бүлийн нэг гишүүнд ногдох амьжиргааны доод түвшинг тогтоох тухай	
30.	1998.1.15, №5	Хүн амын эрүүл мэндийн боловсрол үндэсний хөтөлбөр батлах тухай	Иргэдэд эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх талаар мэдлэг өгөх	Нийгэм соёлын эрх
31.	1998.2.12, №15	Журам батлах тухай	Цэргийн албыг гэрээгээр хаах журам батлах тухай	Нийгэм соёлын эрх
32.	1998.2.18, №21	Журам батлах тухай	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай	Улс төрийн эрх
33.	1998.3.25, №41	Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай	Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай	Нийгэм соёлын эрх

34.	1998.6.10, №92	Нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг шинэчлэн тогтоох тухай		Нийгэм соёлын эрх
35.	1998.6.23, №104	Хөтөлбөр батлах тухай	Залуучуудын үндэсний хөтөлбөр баталсан, залуучуудын талаар төрөөс явуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар	Нийгэм соёлын эрх
36.	1998.7.29, №130	Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, үндэсний хөтөлбөр батлах тухай	Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах, амьжиргааны баталгааг хангах чиглэлээр авах арга хэмжээг эрчимжүүлэх	Нийгэм соёлын эрх
37.	1998.11.4, №202	Хөтөлбөр батлах тухай	Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг батлах	Нийгэм соёлын эрх
38.	1998.11.25, №211	Журам батлах тухай	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр оруулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам	Нийгэм соёлын эрх
39.	1999.2.10, №25	Хөтөлбөр батлах тухай	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр	Нийгэм соёлын эрх
40.	1999.2.22, №30	Улсын хилийн хамгаалалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай	Хил орчмын иргэдийн амгалан тайван байдлыг хангах тухай орсон	Нийгэм соёлын эрх
41.	1999.3.3, №36	Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай, тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай, халамжийн сангийн дүрэм	Нийгэм соёлын эрх
42.	1999.3.10, №43	Хөтөлбөр батлах тухай	Усны үндэсний хөтөлбөр батлах тухай	Нийгэм соёлын эрх
43.	1999.3.24, №49	Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг тогтоох тухай	Аймаг, нийслэлд ялгавартай тогтоосон байна, ж:Архангайд 70, Увсад-35, Сэлэнгэд-19 гэх мэт	Нийгэм соёлын эрх
44.	1999.3.24, №50	Хөтөлбөр батлах тухай	Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр батлах тухай	Нийгэм соёлын эрх

45.	1999.4.14, №58	Дүрэм батлах тухай	Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээний тухай дүрэм	Нийгэм соёлын эрх
46.	1999.4.21, №61	Орон сууц хувьчлах тухай	Гадаад харилцааны яамны 33 айлын орон сууцыг эзэмшигчдэд нь хувьчлах	Нийгэм соёлын эрх
47.	1999.4.21, №62	Бангкокийн тунхаглалыг хүлээн зөвшөөрөх тухай	Хүүхдийн сайн сайхны төлөө Бангкокийн тунхаглалыг хүлээн зөвшөөрөх тухай	Нийгэм соёлын эрх
48.	1999.5.25, №82	Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай	Агаарыг хамгаалах хөтөлбөр батлах тухай	Нийгэм соёлын эрх
49.	1999.6.2, №87	Журам батлах тухай	Байлдаанд оролцсон ахмад дайчдад үнэмлэх, тэтгэмж олгох журам батлах тухай	Нийгэм соёлын эрх
50.	1999.6.23, №103	Бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний тухай		Нийгэм соёлын эрх
51.	1999.6.23, №104	Журам батлах тухай	Озон задалдаг бодисыг импортлох, ашиглах зөвшөөрөл олгох журам	Нийгэм соёлын эрх
52.	1999.6.30, №105	Хөтөлбөр батлах тухай	Цагаан хувьсгал үндэсний хөтөлбөр	Нийгэм соёлын эрх
53.	1999.7.14, №114	Эх, нярайн халдвараас сэргийлэх зарим арга хэмжээний тухай	Амаржих газруудад ариутгал, халдваргүйтэл, халдварын эсрэг дэглэм сахиулах, түүнд тавих хяналтыг сайжруулах	Нийгэм соёлын эрх
54.	1999.7.28, №115	Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай	НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай	Нийгэм соёлын эрх
55.	1999.8.4, №120	Ховд аймгийн Алтайн чанад дахь бүс нутгийн хөгжлийн талаар авах арга хэмжээний тухай	Хүн амын амьжиргаа доройтож байгааг харгалзан хөнгөлттэй зээл, тусгай зориулалтын сангийн хөрөнгө ашиглах тухай	Нийгэм соёлын эрх
56.	1999.8.11, №122	Журам, дүрэм батлах, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Ажлын цагийг нэгтгэн бодох журам, хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм	Нийгэм соёлын эрх
57.	1999.8.11, №123	Үндэсний хороо байгуулах тухай	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны дүрэм	Нийгэм соёлын эрх
58.	1999.8.11, №124	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар ЗГ-аас баримтлах бодлогыг батлах		Нийгэм соёлын эрх

		тухай		
59.	1999.8.25, №128	Хөтөлбөр батлах тухай	Озоны үе давхрагыг хамгаалах үндэсний хөтөлбөр	Нийгэм соёлын эрх
60.	1999.9.15, №147	Хөтөлбөр батлах тухай	Сум, суурин газрын дулаан хангамжийн хөтөлбөр /халаалт, халуун ус/	Нийгэм соёлын эрх
61.	1999.9.15, №149	Өрхийн эмнэлэг байгуулан ажиллуулах тухай	Өрхийн эмнэлгийн үлгэрчилсэн дүрэм	Нийгэм соёлын эрх
62.	1999.10.1, №157	Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай		Нийгэм соёлын эрх
63.	1999.11.17, №189	Журам батлах тухай	Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам	Нийгэм соёлын эрх
64.	1999.11.24, №200	Дайчилгааны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журам	Нийгэм соёлын эрх
65.	1999.12.22, №220	Дүрэм батлах тухай	Оюуны өмчийн улсын хяналтын дүрэм	Нийгэм соёлын эрх
66.	1999.12.29, №229	Хөтөлбөр батлах тухай	Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр	Нийгэм соёлын эрх
67.	2000.1.5, №2	Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай		Нийгэм соёлын эрх
68.	2000.1.9, №9	Иргэний үнэмлэх төлбөргүй олгох тухай	Өндөр настнуудад нэг удаа төлбөргүй олгох тухай	Нийгэм соёлын эрх
69.	2000.1.21, №10	Хуулийн биелэлтийг зохион байгуулж хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	Хөдөлмөрийн тухай хуулийн биелэлт хангагдаж байгаа эсэх талаар улс орон даяар явуулсан үзлэг, шалгалт	Нийгэм соёлын эрх
70.	2000.2.2, №19	Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Улс төрийн хилс хэрэгт холбогдогчдыг цагаатгах, нөхөн олговор олгох тухай асуудал	Нийгэм соёлын эрх
71.	2000.2.9, №28	Журам батлах тухай	/Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний	Нийгэм соёлын

			хөлсийг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хувь этгээдээс хураан төвлөрүүлэх журам/	эрх
72.	2000.2.23, №33	2000 онд цэргийн дүйцүүлэн хаалгах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай		Нийгэм соёлын эрх
73.	2000.3.1, №34	Хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай	Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр	Нийгэм соёлын эрх
74.	2000.3.8, №37	Хөтөлбөр батлах тухай	Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	Нийгэм соёлын эрх
75.	2000.6.21, №96	Журам шинэчлэн батлах тухай	Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам	Нийгэм соёлын эрх
76.	2000.7.5, №107	Дүрэм батлах тухай	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судлах бүртгэх дүрэм	Нийгэм соёлын эрх
77.	2000.9.27, №148	Согтуурах, мансуурах донтой өвчтөний талаар авах зарим арга хэмжээний тухай	Албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх газар байгуулахтай холбогдолтой	Нийгэм соёлын эрх
78.	2000.10.6, №157	Хүүхдийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай	Хүүхдийн төлөө үндэсний хорооны дүрэм, хүүхдийг хөгжүүлэх талаар ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	Нийгэм соёлын эрх
79.	2000.10.6, №158	Журам батлах тухай	Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам	Нийгэм соёлын эрх
80.	2001.1.24, №11	Дүрэм, журам шинэчлэн батлах тухай	Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газрын дүрэм, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн улсын бүртгэгчийн ажиллах журам	Нийгэм соёлын эрх
81.	2001.1.24, №16	2001 оныг Тахир дутуу иргэдийг дэмжих жил болгох тухай		Нийгэм соёлын эрх
82.	2001.1.31, №22	Үндэсний зөвлөл байгуулах тухай	Эмэгтэйчүүдийн талаархи үндэсний зөвлөлийг Хүйсийн тэгш эрхийн талаарх үндэсний зөвлөл болгох асуудал	Нийгэм соёлын эрх
83.	2001.3.28, №61	Тооны дээд хязгаар тогтоох	цэргийн дүйцүүлэн хаалгах иргэдийн тооны	Нийгэм соёлын

		тухай	дээд хязгаарыг тогтоох тухай	эрх
84.	2001.4.11, №78	Журам батлах тухай	Хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх журам	Нийгэм соёлын эрх
85.	2001.5.10, №108	Хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай	Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр	Нийгэм соёлын эрх
86.	2001.6.5, №119	Хөтөлбөр батлах тухай	Сургуулийн өмнөх боловсрол-2 үндэсний хаталбөр	Нийгэм соёлын эрх
87.	2001.6.6, №124	Дүрэм батлах тухай	Дипломат ажилтны сахилгын дүрэм	Нийгэм соёлын эрх
88.	2001.6.27, №139	Журам батлах тухай	Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам	Нийгэм соёлын эрх
89.	2001.7.4, №146	Нөхөн төлбөр олгох тухай	Налайх дүүргийн уурхай, зарим үйлдвэр, АА-н газарт ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас тахир дутуу болж хөдөлмөрийн чадвараа алдсан боловч 1995 оноос хойш нөхөн төлбөрөө авч чадаагүй байгаа иргэдэд нөхөн олговор олгох тухай	Нийгэм соёлын эрх
90.	2001.7.4, №153	Хөтөлбөр батлах тухай	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөр	Нийгэм соёлын эрх
91.	2002.4.3, №59	“Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлах тухай	-Сэтгэцийн эмгэг жилээс жилд нэмэгдэх хандлагатайг харгалзан түүнээс урьдчилан сэргийлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх	Нийгэм соёлын эрх
92.	2002.5.1, №84	Иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай	-Хүүхэд, өсвөр насныхны оюун ухааны хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг иод дутлын эмгэгийг устгах, урьдчилан сэргийлэх	Нийгэм соёлын эрх
93.	2002.7.16, №156	Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр батлах тухай	Төрөл бүрийн осол гэмтэл болон нас барагсдын тоо эрс өссөнтэй холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдэд учирч	Нийгэм соёлын эрх

			болох хохирлыг барагдуулах	
94.	2002.10.22, №214	МУ-ын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам		Нийгэм соёлын эрх
95.	2002.12.4, №245	Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай		Нийгэм соёлын эрх
96.	2002.12.4, №248	Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийн талаар авах арга хэмжээний тухай		Нийгэм соёлын эрх
97.	2002.12.30, №274	Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай		Нийгэм соёлын эрх
98.	2003.1.6, №3	Журам батлах тухай	Монгол улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам	Нийгэм соёлын эрх
99.	2003.1.15, №7	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Шийтгэвэр, торгуулийн хуудасны маягтыг баталж, шийтгэвэр болон торгуульд давж заалдах 10 хоногийн хугацаа заасан байна.	Нийгэм соёлын эрх
100.	2003.1.22, №13	Дүрэм батлах тухай	Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм баилах тухай	Нийгэм соёлын эрх
101.	2003.3.12, №62	Журам батлах тухай	МУ-ын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам	Нийгэм соёлын эрх
102.	2003.4.2, №79	Журам батлах тухай	Гадаадын иргэнийг МУ-аас албадан гаргах журам	Нийгэм соёлын эрх
103.	2003.6.4, №138	Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай		Нийгэм соёлын эрх
104.	2003.6.4, №139	Сургалтын төлбөрийн тухай		Нийгэм соёлын эрх
105.	2003.7.7, №168	Журам батлах тухай	Гадааадын иргэн МУ-д түр, удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух цагаачлах журам	Нийгэм соёлын эрх
106.	2003.7.15, №172	МУ-ын виз олгох журамд		Нийгэм соёлын

		нэмэлт өөрчлөли оруулах тухай		эрх
107.	2003.8.6, №184	Улсын нөөцөөс гэр олгох, нөхөн бүрдүүлэх тухай		Нийгэм соёлын эрх
108.	2003.8.6, №185	Хөрөнгө гаргах тухай	Үерт автагдсан хүмүүст туслах	Нийгэм соёлын эрх

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2004 ОНЫ ИЛТГЭЛД ТУСГАХ САНАЛ

Засгийн газрын тогтоол ба хүний эрх.

1.1 Шинэ Үндсэн хууль 1992 онд батлагдаж хүчин төгөлдөр болсноос хойшхи 12 жилийн хугацаанд манай улсын хууль тогтоомж бүрэн шинэчлэгдсэн. Үүнтэй уялдан 1992 оноос хойш Засгийн газраас батлан гаргасан тогтоолууд шинээр бий болж буй эрх зүйн харилцааг зохицуулахад чиглэж иржээ. Засгийн газраас 1992-2003 онд 2838 тогтоол баталж гаргаснаас хүчин төгөлдөр үйлчилж буй 2390 тогтоол байна. Үүнээс хүний эрхэд ямар нэг талаар хамааралтай 108 тогтоол байна. Эдгээр тогтоолын ихэнхи нь хүний эрхийн нийгэм, соёлын эрхэд хамаарах заалтуудтай холбоотой байна.

1.2 Дээр дурьдсан Засгийн газраас баталсан хүний эрхтэй холбогдолтой тогтоолуудад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээний заалттай зөрчилдсөн зарим тогтоол байна. Эдгээр тогтоолтой холбогдолтой зарим асуудлыг авч үзье.

1.3 “Ой, хээрийн түймрийн үед хүн хүч, техник, хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах журам” /1997.04.30, №107/-д дайчилгаагаар ажилласан иргэнд хуулийн дагуу нөхөн олговор олгох ёстой байтал энэ тухай тусгаагүй бөгөөд дайчилгаанд 18 нас хүрээгүй хүүхдийг хамруулсан зэрэг нь Улс төр, нийгэм, соёлын олон улсын пакт, Хүүхдийн эрхийн конвенцийн холбогдох заалттай зөрчилдөж байгаа юм.

1.4 “Цэргийн албыг дүйцүүлэн хаалгах иргэдийн тооны дээд хэмжээг тогтоох тухай” /2000.2.23, №33, 2001.3.28, №61/ тогтоолоор аймаг тус бүрт өөр өөр хязгаар тогтоосон байна. Тухайлбал: Архангайд 120, Улаанбаатарт 55, Говь-Алтай 15, Дархан-Уул 35 гэх мэт тухайн жилд улсын хэмжээнд нийт 1000 хүн байхаар тогтоосон нь “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхтэй” гэсэн Үндсэн хуулийн 16.18 дугаар заалт болон Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний зарим заалттай зөрчилдөж байна.

1.5 “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж өгөх, эргэж төлүүлэх журам” /2000.6.21, №96/-д зээлийг 3 хувийн хүүтэйгээр буцаан төлүүлж байхаар тогтоосон нь Монгол Улсын Иргэний хуулийн 202.1, 202.2, 202.2.5, 202.2.15 болон “Эдийн засаг, нийгэм, соёлын тухай олон улсын пакт”-ын 13.1-ийн в, д хэсэгт заасан заалттай зөрчилдөж байна.

1.6 “Гаалийн улсын байцаагчийн сахилгын тусгай дүрэм” /2003.01.22, №13/ -ийн 3.1.3-т “гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлт хийсний төлөө ... хоол, цайллаганд уригдах зэрэг хууль бус хангамж эдлэхийг хориглоно” гэсэн бөгөөд энэ заалтыг зөрчвөл сахилгын шийтгэл ногдуулна. “Сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг дахин гаалийн албанд авахаас татгалзах үндэслэл болно” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.4, Хөдлөмрийн хуулийн 40.1.4 болон ОУХБ-ын 111 дүгээр конвенцийн 1.1.6 хэсэгт заасан заалттай зөрчилдөж байна.

Засгийн газраас баталсан дээр дурьдсан тогтоолууд Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээний холбогдох заалтыг зөрчиж буй тул тэдгээрт зарим нэмэлт, өөрчлөлт оруулахаар холбогдох байгууллагад санал болгож болгохоор төлөвлөж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ САНАЛ

Дор дурдсан Засгийн газрын тогтоолын холбогдох заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахыг санал болгож байна. Үүнд:

1. “Ой, хээрийн түймрийн үед хүн, хүч, техник, хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах журам” /1997.04.30, №107/-ын 21 дүгээр зүйлд “16-60 хүртэлх насны эрэгтэй” гэснийг “18-60 хүртэлх насны эрэгтэй” гэж, “16-55 хүртэлх насны эмэгтэй” гэснийг “18-55 хүртэлх насны эмэгтэй” гэж өөрчлөх,
2. “Цэргийн албыг дүйцүүлэн хаалгах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай” тогтоол /жишээлбэл: 2000.2.23, №61/-оор аймаг тус бүрт өөр өөр тоо тогтоосныг нэг болгох,
3. “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргүүлж төлүүлэх журам” /2000.6.21, №96/-ын 31-т “ . . . сургалтын төлбөрийн зээл, тусламж, тэтгэлгийг зогсоож суралцахгүй болсон тухайн сараас 2 жилийн дотор буцааж төлүүлнэ” гэж өөрчлөх,
4. “Гаалийн улсын байцаагчийн сахилгын тусгай дүрэм” /2003.01.22, №13/-ийн 3.1.3-ын заалтаас “ . . . хоол, цайллаганд уригдах” гэснийг хасаж найрууулах.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ БОЛОВСРУУЛЖ БУЙ АЛБАН
ТУШААЛТАНД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Улаанбаатар хот

1. Илтгэлийн сэдэв:

1. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн холбогдолтой олон улсын гэрээний эрх зүйн үр нөлөө
/Энэ сэдвээр мэргэшсэн судлаач/
2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэм хэмжээг Монгол Улсын засгийн газрын тогтоолд үндэслэл болгох практик үйл ажиллагаа
/Засгийн газар болон яамны тогтоол боловсруулах эрх бүхий албан тушаалтан/
3. Монгол Улсын нэгдэн орсон нийгэм, хөдөлмөрийн эрх зүйн харилцаатай холбогдолтой олон улсын гэрээ ба Монгол Улсын эрх зүйн зохицуулалт
/Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яамны ажилтан/

2. Сургалтад хамрагдах хүмүүс:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын холбогдох ажилтан
2. Яам, агентлагийн хууль зүй, гадаад харилцааны хэлтсийн ажилтан
3. Дээрх сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж буй эрдэм шинжилгээний ажилтан, судлаач

3. Сургалт зохион байгуулах байгууллага:

1. Хүний эрхийн үндэсний комисс
2. Хууль зүйн үндэсний төв

4. Сургалт зохион байгуулах хугацаа:

- ❖ 2004 оны 2 дугаар сарын 10-ны өдөр

ОИГ.МН
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, ХУУЛЬ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ
ХҮНИЙ ЭРХИЙН ХОЛБОГДОЛТОЙ ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ГЭЖ ҮЗЭЖ БУЙ
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫН ХЭМ ХЭМЖЭЭГ ТАЙЛБАРЛАХАД
АШИГЛАСАН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗҮЙЛ, ХЭСЭГ**

Нэг. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС (1992 он)

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Арван дөрөвдүгээр зүйл

1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Арван тавдугаар зүйл

1. Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.

2. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.

Арван зургадугаар зүйл

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;

2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;

4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;

5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;

6/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;

7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно.

10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;

13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө

өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;

16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИАС (1992 он)

12.5. Монгол Улсын 18-25 насны, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэг бүхий иргэн шашин шүтлэг-ёс зүйн шалтгаанаар цэргийн албыг дүйцүүлэн хааж болно. Цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлтэй иргэн Иргэний хамгаалалтын мэргэжлийн анги, Байгалийн гамшигтай тэмцэх салбар, Хилийн цэрэгт туслах хүчин болон хүмүүнлэгийн бусад байгууллагад алба хаана. Уг албыг хаах хугацаа 24 сар байна. Иргэний хамгаалалтын хойшлуулшгүй арга хэмжээ, улсын хил хамгаалалтын зайлшгүй шаардлагыг харгалзан Засгийн газар энэхүү хугацааг 3 хүртэл сараар сунгаж болно.

Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам, алба хаах иргэний тооны дээд хязгаарыг Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/

Гурав. МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛИАС (2002 он)

Гуравдугаар дэд бүлэг

Гэрээний стандарт нөхцөл

200 дугаар зүйл. Стандарт нөхцөл гэрээний салшгүй хэсэг болох

200.1. Гэрээний нэг тал нь нөгөөдөө санал болгож байгаа, хуулиар тодорхойлоогүй буюу хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон, байнга хэрэглэгдэх, урьдчилан тогтоосон нөхцөлийг гэрээний стандарт нөхцөл гэнэ.

200.2. Талууд нэг бүрчлэн тохиролцож тогтоосон нөхцөлийг гэрээний стандарт нөхцөл гэж үзэхгүй.

200.3. Дараахь нөхцөл бүрдсэн тохиолдолд стандарт нөхцөл нь талуудын хооронд байгуулсан гэрээний салшгүй хэсэг болно:

200.3.1. санал гаргагч тал нь гэрээ байгуулж байгаа газарт стандарт нөхцөлийг ил тод харагдахаар бичиж энэ нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй гэрээг байгуулахаар заасан бол;

200.3.2. нөгөө тал нь дээрх нөхцөлтэй танилцах боломжтой байсан бөгөөд уг нөхцөлийг зөвшөөрсөн бол.

200.4. Санал хүлээн авагч тал нь аж ахуй эрхлэгч этгээд бөгөөд ажил хэргийн онцлогоос хамаарч стандарт нөхцөлийг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан бол стандарт нөхцөл нь гэрээний салшгүй хэсэг болно.

200.5. Стандарт нөхцөлийг илэрхийлсэн гадаад нөхцөл нь хэвшсэн хэлбэрээс өөр байсан учир нөгөө тал нь түүнийг урьдчилан мэдэх боломжгүй байсан бол стандарт нөхцөл нь гэрээний салшгүй хэсэг болохгүй.

201 дүгээр зүйл. Стандарт нөхцөлийг тайлбарлах

201.1. Стандарт нөхцөлийг илэрхийлсэн үг хэллэгийн утга санаа ойлгомжгүй бол түүнийг санал хүлээн авагч талд ашигтайгаар тайлбарлана.

202 дугаар зүйл. Стандарт нөхцөл хүчин төгөлдөр бус байх

202.1. Стандарт нөхцөлийг гэрээнд тусгасан ч тэр нь харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талдаа хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус байна. Энэ тохиолдолд стандарт нөхцөлийг гэрээнд тусгах болсон нөхцөл байдал, талуудын ашиг сонирхол болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

202.2. Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй иргэнтэй гэрээ байгуулахаар санал гаргаж байгаа тал нь дараахь нөхцөлүүдийг гэрээний стандарт нөхцөлд тусгасан бол тэдгээр нь хүчин төгөлдөр бус байна:

202.2.1. саналыг хүлээн авах, түүнээс татгалзах зэрэгт хэт урт буюу тодорхой бус хугацаа тогтоосон;

202.2.2.үүргээ гүйцэтгэхэд хэт урт буюу тодорхой бус, хуульд үл нийцэх хугацаа тогтоосон;

202.2.3.гэрээнд заагаагүй бөгөөд тодорхой үндэслэлгүйгээр гэрээг цуцлах эрхтэй байхаар заасан;

202.2.4.гэрээгээр нэгэнт тогтоосон үүргээ нөгөө талын хууль ёсны ашиг сонирхолд үл нийцэх байдлаар өөрчлөх буюу татгалзах эрхтэй байхаар заасан;

202.2.5.гаргасан зардлыг хэт өндрөөр буюу нэмэгдүүлэн тооцож шаардах эрхийг өөртөө олгосон;

202.2.6.онцгой ач холбогдол бүхий тайлбарыг нөгөө талд гаргасанд тооцохоор заасан;

202.2.7.урт хугацаатай үүргийн харилцаанд үнийг үндэслэлгүйгээр хэт богино хугацаанд огцом өсгөхөөр заасан;

202.2.8.нөгөө талын үүргээ гүйцэтгэх, эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах хуулиар олгогдсон эрхийг хязгаарласан буюу үгүйсгэсэн;

202.2.9.нөгөө талдаа үүргээ гүйцэтгэхийг урьдчилан сануулах буюу үүргээ гүйцэтгэх боломжийн хугацаа олгох хуулиар тогтоосон үүргээс санал гаргагч талыг чөлөөлсөн;

202.2.10.санал гаргагч тал нь өөрт учирсан бодит хохирлоос хэт давсан хэмжээний нөхөн төлбөр шаардахаар тогтоосон;

202.2.11.санал гаргагч, түүний хууль ёсны төлөөлөгч зэрэг этгээдийн санаатай буюу хэт болгоомжгүй үйлдлийн улмаас учирсан хохирлыг хариуцахыг үгүйсгэсэн буюу хязгаарласан;

202.2.12.үүргээ зөрчсөнөөс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах нөгөө талын эрхийг хязгаарласан;

202.2.13.санал гаргагч тал нь үүргээ хэсэгчлэн гүйцэтгэснээс нөгөө талын хууль ёсны ашиг сонирхол хохирох тохиолдолд гэрээнээс татгалзах, гэрээгээ цуцалж, үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан хохирлыг бүхэлд нь шаардах эрхийг үгүйсгэсэн;

202.2.14.санал гаргагч талын бэлтгэн нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний дутагдлын талаар хүлээх хариуцлагыг хуульд зааснаас бага хэмжээгээр тогтоосон;

202.2.15.санал гаргагч тал хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс нөгөө тал гэрээг цуцалсан бол санал гаргагч талд анз төлөхөөр заасан.

202.3.Бараа бүтээгдэхүүн тогтмол нийлүүлэх буюу ажил, үйлчилгээ тогтмол явуулах тухай гэрээний стандарт нөхцөлд дараахь нөхцөлийг тусгасан бол тэдгээр нөхцөл нь хүчин төгөлдөр бус байна:

202.3.1. нөгөө талд хоёроос илүү жилийн хугацаагаар үүрэг хүлээлгэж байгаа;

202.3.2. аль нэг тал нь гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг тухай бүр нэг жилээс урт хугацаагаар сунгасанд тооцохоор тогтоосон;

202.3.3. гэрээг цуцлах хугацаа нь гэрээг сунгасанд тооцох хугацаанаас гурван сараас илүү байхаар заасан нь нөгөө талын хууль ёсны ашиг сонирхолд үл нийцэхээр бол.

202.4. Дор дурдсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээд санал гаргагч талын оронд түүнтэй адил эрхтэйгээр тухайн гэрээний харилцаанд оролцохоор заасан буюу оролцох бололцоотой байхаар тогтоосон бол стандарт нөхцөл хүчин төгөлдөр бус байна:

202.4.1. гуравдагч этгээдийг нэрээр нь заасан;

202.4.2. нөгөө талд дангаар гэрээг цуцлах эрх олгосон.

202.5. Гэрээний стандарт нөхцөлд хамаарах хэсгүүдийн аль нэг нь хүчин төгөлдөр бус байх, эсхүл гэрээний гол бус нөхцөл болсон тохиолдолд гэрээ бүхэлдээ хүчин төгөлдөр байна.

Дөрөв. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИАС (1996 он)

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

1. Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ.

2. Энэ хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна.

Тав. МОНГОЛ УЛСЫН ХӨДЛМӨРИЙН ХУУЛИАС (1998 он)

40 дүгээр зүйл. Хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцлах

40.1. Хөдөлмөрийн гэрээг дараахь үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар цуцалж болно:

40.1.1. аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн;

40.1.2. ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон;

40.1.3. ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн;

40.1.4. ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан;

40.1.5. мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон;

40.1.6. сонгууль, томилолтоор өөр орон тооны ажил, албан тушаалд ажиллах болсон;

40.1.7. контрактад заасан үндэслэл буй болсон.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**СУДАЛГААНД АШИГЛАСАН МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН
ХҮНИЙ ЭРХИЙН ХОЛБОГДОЛТОЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**

1. Дайтаж байгаа армийн шархадсан ба өвчтэй цэргийг асран хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн нэгдүгээр конвенц /1958
2. Тэнгисийн зэвсэгт хүчний шархдагсад, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд нэрвэгдэгсдийг асран хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн хоёрдугаар конвенц /1958
3. Дайнд олзлогдогсодтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн гуравдугаар конвенц/1958
4. Дайны үед энгийн хүн амыг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн дөрөвдүгээр конвенц /1958
5. Боловсролын талаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх тухай конвенц 1960/1964
6. Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц 1953/1965/
7. Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчийг шийтгэн цээрлүүлэх тухай конвенц 1948/1967
8. Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой төсөөтэй харилцаа, үйл ажиллагааг устгах тухай нэмэлт конвенц 1956/1968
9. Арьс үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц 1966/1969
10. Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай конвенц 1968/1969
11. Аж үйлдвэрт хүүхдийг ажилд авах насны доод хязгаарын тухай 1937 онд хянаж өөрчилсөн конвенц 1937/1969
12. Эхчүүдийг хамгаалах тухай конвенц 1952/1969
13. Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай конвенц 1958/1969
14. Зохион байгуулах, хамтын хэлэлцээр хийх эрхийн тухай конвенц 1949/1969
15. Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш шан хөлс олгох тухай конвенц 1951/1969
16. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966/1974
17. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966/1974
18. Апартейдийн гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай олон улсын конвенц 1973/1975
19. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай конвенц /ОУХБ-ын 122-р конвенц/ 1964/1976
20. Газар доорхи ажилд авах насны доод хязгаарын тухай /ОУХБ-ын 123-р конвенц/
21. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц 1979/1981
22. Спортод апартейд бодлого явуулахын эсрэг олон улсын конвенц 1985/1987
23. Ажилчдын төлөөлөгчдийн тухай конвенц 1971/1989
24. Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989/1990
25. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол I 1966/1991

26. Сайн дурын үндсэн дээр гэрлэх тухай болон, гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай конвенц 1962/1991
27. Хүмүүсийг барьцаанд авахтай тэмцэх тухай олон улсын конвенц 1979/1992
28. Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвшилцлийн тухай /ОУХБ-ын 144-р конвенц 1976/1993
29. Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн Конвенцийн нэмэлт протокол
30. Олон улсын бус чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн Конвенцийн нэмэлт протокол 1977/1995
31. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай ОУХБ-ын 155-р конвенц, 164-р зөвлөмж/ 1981/1996
32. Тахир дутуу иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт ба хөдөлмөр эрхлэлтийн тухай /ОУХБ-ын 159-р конвенц, 168-р зөвлөмж 1983/1996
33. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 43 дугаар зүйлийн /2/ нэмэлт өөрчлөлт 1995/1997
34. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай конвенц /ОУХБ-ын 182 дугаар конвенц 1999/2000
35. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц 1984/2000
36. Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц 1993/2000
37. Зэвсэгт мөргөлдөөнд оролцуулах, худалдах, янхан болгох болон садар самуунаас хүүхдийг хамгаалах талаархи Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол 1999/2002
38. Ажилд авах насны доод хязгаарын тухай конвенц /ОУХБ-ын 138 дугаар конвенц 1973/2002
39. Олон улсын Эрүүгийн Шүүхийн Ромын Дүрэм 1998/2002

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, ХУУЛЬ, ОЛОН УЛСЫН
ГЭРЭЭНИЙ ХҮНИЙ ЭРХИЙН ХОЛБОГДОЛТОЙ ЗААЛТЫГ
ЗӨРЧСӨН ГЭЖ ҮЗЭЖ БУЙ ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛЫН ХУУЛБАР**

1. ЖУРАМ, ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

/Ой, хээрийн түймрийн үед хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах журам, Ой, хээрийн түймрийг унтраах ажилд оролцож буй иргэдийн хангамж, тэдгээрийн заавал эзэмшсэн байх зүйлийн жагсаалт/

1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр, дугаар 107

**2. 2000 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААЛГАХ ИРГЭДИЙН
ТООНЫ ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООХ ТУХАЙ**

2000 оны 2 дугаар сарын 23-ны өдөр, дугаар 33

3. ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

/Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж огох, эргэж төлүүлэх журам/

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр, дугаар 96

4. ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР ТОГТООХ ТУХАЙ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр, дугаар 61

5. ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

/ Гаалийн улсын байцаагчийн сахилгын тусгай дүрэм /

2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр, дугаар 13

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

2000 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААЛГАХ ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООХ ТУХАЙ

2000 оны 2 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 33

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.2000 онд цэргийн албыг дүйцүүлэн хаалгах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралтын ёсоор баталсугай.

2.Тогтоосон хязгаарт багтаан цэргийн албыг дүйцүүлэн хаалгах арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай..

3.Орон нутагт цэргийн албыг дүйцүүлэн хаалгах ажлыг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндоржид үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Батлан хамгаалахын сайд

Ш.ТҮВДЭНДОРЖ

2000 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААЛГАХ ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Аймаг, нийслэлийн нэр	Цэргийн албыг дүйцүүлэн хаалгах иргэдийн тооны дээд хязгаар
1	Архангай	60
2	Баян-өлгий	77
3	Булган	30
4	Говь-алтай	50
5	Дорноговь	31
6	Дорнод	60
7	Дундговь	25
8	Завхан	80
9	Өвөрхангай	60
10	Өмнөговь	67
11	Сүхбаатар	20
12	Сэлэнгэ	40
13	Төв	71
14	Увс	52
15	Ховд	75
16	Хөвсгөл	40
17	Хэнтий	45
18	Дархан-уул	16
19	Орхон	12
20	Говьсүмбэр	15
21	Улаанбаатар	59
	БҮГД	985



ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж огох, эргэж төлүүлэх журам /

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр
Улаанбаатар хот

Дугаар 96

Боловсролын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж огох, эргэж төлүүлэх журам"-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталж 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

2. Сургалтын төлбөрийн зээл, тусламжийг 2000 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн төвлөрүүлэн зарцуулж байхыг Сургалтын төрийн сангийн захирал Б.Ганбатад даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам, дүрэм батлах тухай" Засгийн газрын 1997 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 179 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ
Гэгээрлийн сайд А.БАТТӨР

**ИХ СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД СУРАЛЦАГЧДАД СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ЗЭЭЛ, БУЦАЛТГҮЙ
ТУСЛАМЖ ОЛГОХ, ЭРГЭЖ ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг зүйл

1.Боловсролын хуулийн дагуу магадлан итгэмжлэгдсэн их сургууль, коллежийн оюутан, магистрант, докторант, Засгийн газрын гэрээ, хэлэлцээрээр гадаадад суралцагчид (цаашид "суралцагч" гэнэ) сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

Энэхүү журам нь Засгийн газрын гэрээ, хэлэлцээрээр гадаад улсад суралцуулагч талын зардлаар 6 сар хүртэл хугацаагаар мэргэшүүлэх сургалтад суралцагчдад нэгэн адил хамаарна.

2.Боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран сургалтын төлбөрийн зээл болон буцалтгүй тусламжаар суралцах суралцагчдын хяналтын тоог жил бүрийн 5 дугаар сард мэргэжил тус бүрээр нь батлан гаргана.

3.Дээд боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгж нь кредит цаг байна. Нэг кредит цаг нь улирлын туршид нэг долоо хоногт танхимд нэг цагаар орох лекц буюу 2 цагаар орох семинар, дадлага, эсвэл 3 цагаар орох лабораторын ажлын нийт цагтай тэнцүү тоон утгаар хэмжигдэнэ.

4.Их сургууль, коллеж нь суралцагчдын кредит цагийн өртгийг үндэслэн тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг сургуулийн Удирдах зөвлөлийн хурлаар батлуулж 6 дугаар сард нийтэд зарлана.

5.Суралцагчдын улирлын болон суралцсан хугацааны агуулга эзэмшилтийн чанарын түвшинг тогтооход голч дүнг ашиглана. Голч дүн нь дээрх хугацаанд үзсэн хичээлд авсан тоон дүнгийн кредит цагаар жигнэгдсэн дундаж байна.

6.Сургалтын төлбөрийн хөрөнгийг төвлөрүүлэн бүрдүүлэх, зээлийн гэрээг баталгаажуулах, сургалтын зээл олгох, буцааж төлүүлэх, буцалтгүй тусламж өгөх, шаардлагатай бол шүүхэд нэхэмжлэл гаргах, санхүүгийн тайлан гаргах үүргийг Сургалтын төрийн сан хариуцна.

Хоёр.Их сургууль, коллежид сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж, шагналаар суралцуулах нөхцөл

7.Их сургууль, коллежид зохих журмын дагуу шинээр элсэн суралцагч болон амжилттай суралцаж байгаа суралцагчдад дор дурдсан нөхцөлөөр сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж, шагнал олгоно:

а/сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл:

-Үндэсний статистикийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрх, эцэг, эх нь хоёулаа өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч;

-Үндэсний статистикийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хагас өнчин суралцагч;

-их сургууль, коллежийг бакалаврын боловсролоор 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн, магистрантур, докторантурт суралцагч;

-Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад оронд суралцагч.

б/сургалтын төлбөр, тэтгэлэгийн буцалтгүй тусламж:

-бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, нэн ядуу өрхийн тахир дутуу суралцагч;

в/сургалтын төлбөрийн шагнал:

-олон улсын хэмжээнд зохиогдсон олимпиад, олон улсын дээд зэрэглэлийн уралдаан, тэмцээнд шагналт байр эзэлсэн суралцагч;

-ерөнхий боловсролын сургуулийг төгсөх жилдээ улсын хэмжээнд зохиогддог олимпиадад эхний 3 байр эзэлсэн суралцагч;

-их сургууль, коллежид дараалсан 4 улиралд голч дүнгээрээ 3,8 буюу түүнээс дээш амжилт үзүүлсэн, суралцах хугацаандаа зохих кредит цагийг бүрэн биелүүлсэн суралцагч.

Гурав.Сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээ байгуулах, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

8.Тухайн хичээлийн жилд суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, тусламж олгох асуудлыг хяналтын тоонд багтаан шийдвэрлэж байх үүрэг бүхий 5-аас доошгүй хүнтэй комиссыг их сургууль, коллежийн захирлын тушаалаар байгуулж ажиллуулна. Уг комисс нь сургалтын алба, нягтлан бодогч, оюутны байгууллага, эцэг, эхийн төлөөлөөс бүрдэнэ. Комиссоос гарсан шийдвэрийг үндэслэн сургалтын алба энэхүү журмын дагуу сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээг Сургалтын төрийн сан, суралцагчтай байгуулж, уг гэрээг сунгах буюу цуцлах ажлыг зохион байгуулна.

9.Гэрээг их сургууль, коллежид сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцагч (эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч), Сургалтын төрийн сан, сургалтын албаны хооронд гурвалсан хэлбэрээр байгуулж, нотариатаар гэрчилнэ.

10.Төрийн захиргааны ба үйлчилгээний байгууллага (цаашид "захиалагч" гэнэ)-ын захиалгаар Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад оронд суралцагч болон тус улсын их сургууль, коллежийн магистрантур, докторантурт суралцагч нь тэдгээрийг суралцуулагч байгууллага, Сургалтын төрийн сантай гурвалсан хэлбэрээр гэрээ байгуулж, нотариатаар гэрчилнэ.

11.Сургалтын төрийн сан нь хичээлийн жилийн улирал тутамд суралцагчийн сурлагын талаар сургуулиудаас ирүүлсэн тодорхойлолт болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан голч дүнг харгалзан зээл, тусламжийн гэрээг сунгаж баталгаажуулна.

12.Их сургууль, коллежийн нягтлан бодогч суралцагчийн авсан зээл, тусламжийг зээлийн гэрээ, картад бичилт хийн тухайн хичээлийн жилийн улирал бүрийн эцэст Сургалтын төрийн сантай тооцоо нийлж гурвалсан гэрээний сунгалт болон төгсөгчдийн төлбөрийн хаалт хийнэ.

13.Тус улсын их сургууль, коллежид сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээгээр суралцагч Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр гадаадад шилжин суралцах үед түүний Сургалтын төрийн санд төлөгдөх сургалтын төлбөрийг зээлээр үргэлжлүүлэн олгож болно.

14.Сургалтын төрийн сан, сургууль, суралцагчийн хооронд байгуулах гэрээнд сургалтын төлбөрийн зээл, тусламж олгох, эргэж төлүүлэх талаар талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгана.

15.Сургалтын төрийн сан, захиалагч, суралцагчийн хооронд байгуулах гэрээнд тухайн суралцагчийн суралцах хугацаа, түүний ажлын байр болон сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх талаар талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгана.

16.Сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээний загварыг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

Дөрөв.Сургалтын төлбөрийн зээл, тусламж авахад суралцагчийн бүрдүүлэх материал

17.Сургалтын төлбөрийн зээл болон буцалтгүй тусламж авахдаа суралцагч дараахь материалыг бүрдүүлнэ:

а/их сургууль, коллежид элссэнийг нотлох элсэлтийн төв комиссоос олгосон томиллолт; магистрантур, докторантурт суралцуулах тухай сургуулийн шийдвэр; Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр гадаадын их сургуульд суралцуулах тухай боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;

б/сургалтын төлбөрийн зээл, тусламж хүссэн болон түүнийг буцааж төлөх тухай нотолсон суралцагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гараар бичсэн өргөдөл;

в/иргэний үнэмлэхийн хуулбар;

г/энэхүү журмын 7-гийн "б"-д заасан суралцагчийн хувьд эцэг, эх, асран хамгаалагч нь нас барсан тухай гэрчилгээний хуулбар;

д/зээлийн төлбөрийн хөрөнгийн баталгааны нотариатын гэрчилгээ;

е/Үндэсний статистикийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрх болох тухай (Улаанбаатар хотоос суралцагчийн хувьд харьяалах хорооны дарга, дүүргийн Засаг даргын Тамгын газрын, орон нутгаас суралцагчийн хувьд сумын болон аймгийн Засаг даргын Тамгын газрын) тодорхойлолт;

ж/энэ журмын 7-гийн "а"-д заасан суралцагчийн өрхийн гишүүдийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, тахир дутуу болохыг тогтоосон холбогдох байгууллагын шийдвэр;

з/энэ журмын 7-гийн "б"-д заасан суралцагчийн тахир дутуу болохыг тогтоосон холбогдох байгууллагын шийдвэр;

и/итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тухай нотариатын гэрчилгээний хуулбар.

Тав.Сургалтын төлбөрийн зээл, тусламжийг санхүүжүүлэх, түүнийг зогсоох

18.Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцагчдад шаардагдах хөрөнгийг жил бүрийн төвлөрсөн төсөвт тусгана. Төсвийг төлөвлөхдөө өмнө нь олгосон зээл, түүний хүүгийн төлбөрийн орлогыг оруулж тооцно.

19.Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургалтын төлбөрийн зээл, тусламжийн хөрөнгийг тухайн жилийн улирал тутам Сургалтын төрийн санд шилжүүлнэ.

20.Сургалтын төлбөрийн зээл, тусламжаар суралцагчдын төлбөрийг төрийн өмчийн их сургууль, коллежийн нийтэд зарласан сургалтын төлбөрийн жишиг, кредит цагийн биелэлтээр Сургалтын төрийн сангаас батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлнэ.

21.Үндэсний статистикийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хагас өнчин оюутанд хичээлийн жил тутмын сургалтын төлбөрийн 150000 төгрөгийг буцалтгүй тусламж хэлбэрээр, үлдэх төлбөрийг нь зээлийн гэрээгээр олгоно.

22.Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, тахир дутуу бөгөөд дипломын болон бакалаврын боловсрол эзэмшихээр суралцагчдад сургалтын төлбөр болон тэтгэлгийг буцалтгүй тусламж хэлбэрээр гэрээгээр олгоно. Тэтгэлгийн хэмжээг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

23. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр доорхи болзлыг хангасан суралцагчдын сургалтын төлбөрийг шагналын хэлбэрээр Сургалтын төрийн сангаас санхүүжүүлнэ:

а/олон улсын хэмжээнд зохиогдсон олимпиад болон олон улсын зэрэглэлтэй уралдаан, тэмцээнд шагналт байр эзэлсэн их сургууль, коллежид бакалаврын боловсрол эзэмшихээр суралцагчдад сургалтын хөтөлбөрийн агуулгыг эзэмших хугацаанд;

б/ерөнхий боловсролын сургуулийг төгсөх жилдээ улсын хэмжээнд зохиогдсон олимпиадад эхний 3 байр эзэлж уг чиглэлээрээ их сургууль, коллежид элсэн суралцагчдад эхний 2 жилд;

в/суралцсан хугацаандаа авбал зохих кредит цагийг бүрэн биелүүлж, дараалсан 4 улирлын голч дүн нь 3,8-аас дээш амжилт үзүүлсэн оюутанд энэхүү хугацаанд;

г/суралцсан хугацаандаа авбал зохих кредит цагийг бүрэн биелүүлж, эхний жилийн голч дүнгээрээ 3,8-аас дээш амжилт үзүүлсэн болон тухайн сургууль, их сургууль, коллежийн хэмжээнд зохиогдсон эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, шилдэг бүтээлээр шалгарсан магистрант, эрдэм шинжилгээний тодорхой хэсэг нь үйлдвэрлэлд нэвтэрч үр дүн нь гарч байгаа докторантад хамгаалах хүртэлх хугацаанд.

24.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр суралцагчдад тэтгэлэг олгохгүй тохиолдолд боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тэтгэлгийн хэмжээг тогтоож түүнийг зээлээр олгоно. Сургалтын төрийн сан зээлийн тэтгэлгээр суралцаж буй суралцагчдын санхүүжилтийг улирал тутам тухайн оронд суугаа Элчин сайдын яамдаар дамжуулан олгож, түүний тайланг улирал тутам гаргуулна.

25.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр гадаад орноос тус улсын их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөр болон тэтгэлгийг Сургалтын төрийн сангаас хуваарийн дагуу санхүүжүүлнэ. Боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран сургалтын төлбөр, тэтгэлгийн хэмжээг тогтооно.

26.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр суралцагчийн сурлагын байдлын талаархи сургуулийн тодорхойлолтыг үндэслэн Сургалтын төрийн сангаас дараа жилийн сургалтын болон тэтгэлгийн гэрээг сунгаж зээлийг санхүүжүүлнэ.

27.Энэхүү журмын 7-гийн "а", "б"-д заасны дагуу сургалтын төлбөрийн зээл, тусламжаар сурч байгаад Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр гадаад оронд бакалаврын боловсролоор шилжин суралцагчдад сургуульдаа анх очих, төгсөөд бүрмөсөн ирэх замын зардлын зээл олгож болно.

28.Суралцагч хүүхэд төрүүлсэн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар зохих журмын дагуу чөлөө авсан бол зээлийн гэрээг түдгэлзүүлэн сургалтын төлбөр, тэтгэлгийн санхүүжилтийг түр зогсооно.

Зургаа.Сургалтын төлбөрийн зээлийг төлүүлэх, барагдуулах тухай

29.Сургалтын төлбөрийн зээл, тусламжаар суралцагч сургуулиа төгссөн, эсхүл гэрээлэгч талуудын аль нэг нь гэрээг цуцалсан буюу түдгэлзүүлсэн бол тухайн суралцуулагчийг сургаж буй сургуулиас энэ тухай Сургалтын төрийн санд ажлын 10 өдрийн дотор албан ёсоор мэдэгдэнэ.

30.Сургалтын төлбөрийн зээлээр суралцагч сургуулиас хасагдсан, сургуулиа орхисон тохиолдолд тухайн сургууль нь Сургалтын төрийн санд ажлын 5 өдрийн дотор энэ тухай албан ёсоор мэдэгдэнэ. Хэрэв энэ тухай мэдэгдээгүй бол тухайн сургуулийн зээл, тусламжаар суралцагчийн дараа улирлын санхүүжилтээс суутгал хийнэ.

31.Энэхүү журмын 28-д зааснаас бусад шалтгаанаар суралцагч цаашид суралцахгүй болсон тохиолдолд сургалтын төлбөрийн зээл тусламж тэтгэлгийг зогсоож суралцахгүй болсон тухайн сараас эхлэн жилийн 3 хувийн хүүтэйгээр 2 жилийн дотор буцааж төлүүлнэ. Хүүгээс хүү тооцохгүй.

32.Сургалтын төрийн сан хичээлийн жилийн улирал тутам энэхүү журмын 11-д заасны дагуу сурлагын байдлын талаархи сургуулийн тодорхойлолтыг үндэслэн зээл, тусламжаар суралцагчийн гэрээг түдгэлзүүлж, дахин сэргээж болно.

33.Зээлээр суралцагч нь сургалтын хөтөлбөрийг бүрэн дуусмагц түүнийг төгссөсөн сургууль зээлийн картанд зээлийн бичилтийг бүрэн хийж, уг суралцагчаар гарын үсэг зуруулан дипломын хамт Сургалтын төрийн санд албан ёсоор хүлээлгэн өгнө

34.Суралцагч сургалтын төлбөрийн зээлийг сургууль төгссөнөөс хойш 10 жилийн дотор бүрэн төлж барагдуулна. Ингэхдээ эхний 6 жилийн дотор хүүгүй, долоо дахь жилээс эхлэн арилжааны банкны жилийн дундаж хүүгээс 0,5-аар илүү хүүтэйгээр 4 жилийн дотор зээл, хүүгийн хамт төлнө.

35. Суралцагч сургууль төгсөөд холбогдох яам, агентлагаас өгсөн чиглэлийн дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагад эзэмшсэн мэргэжлээрээ нийслэл хотод 8 жил, аймгийн төвд 5 жил, суманд 2 жил үр бүтээлтэй ажиллаж байгаа тохиолдолд тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн хөнгөлөлттэй зээл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлж болно. Уг асуудлыг Сургалтын төрийн сангийн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. */Засгийн газрын 2003 оны 61 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан./*

36.Суралцагч нас барсан болон хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу 70-аас дээш хувиар алдсан нөхцөлд түүнийг зээл болон хүүгийн төлбөрөөс чөлөөлнө.

37.Засгийн газар хоорондын тэнцүү солилцоогоор гадаадад суралцагч нь гэрээ байгуулах болон сунгуулахдаа тус улсын төрийн өмчийн адилтгах их сургуулийн тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн жишгээр Сургалтын төрийн санд сургалтын төлбөр төлнө.

38.Засгийн газар хоорондын тэнцүү солилцоогоор суралцагч нь хичээлийн эхний жилийн дүнгээрээ тухайн орны сурлагын үнэлгээний 75 хувиас дээш амжилт үзүүлснийг нотолсон суралцах сургуулийн тодорхойлолтыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр сургалтын төлбөрөөс чөлөөлж болно.

39.Засгийн газар хоорондын тэнцүү солилцоогоор суралцагч хугацаандаа сургуулиа төгсөж чадаагүй, төгсөөд эх орондоо ирээгүй, захиалагч газартаа 5-аас доошгүй жил ажиллаагүй нөхцөлд сургалтын болон тэтгэлгийн зээлийг авсан өдрөөс эхлэн тооцож банкны өр барагдуулах зээлийн хүүгийн жишгээр суралцагч (итгэмжлэгдсэн төлөөлөгч)-аас төлүүлэх бөгөөд энэ талаар гурвалсан гэрээнд заавал тусгасан байна. Энэхүү төлбөрийг барагдуулах асуудлыг гэрээний дагуу Сургалтын төрийн сан хариуцан гүйцэтгэнэ.

40.Засгийн газрын тэнцүү солилцоогоор гадаадад мэргэжил дээшлүүлэгчид Сургалтын төрийн санд сургалтын төлбөр төлнө. Уг төлбөрийн хэмжээг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

41.Сургалтын төлбөрийн зээл нь их сургууль, коллежид суралцах хугацаанд хүүгүй байна.

Долоо.Хариуцлага

42.Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн гэрээ, тэдгээрийн санхүүжилттэй холбогдон гарсан маргааныг Сургалтын төрийн сангийн Удирдах зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ.

43.Суралцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч түүний өмнөөс холбогдох гэрээнд гарын үсэг зурж байгуулах бөгөөд сунгана. Суралцагч нь сургалтын төлбөр, тэтгэлэг болон замын зардлын зээлийг барагдуулаагүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгч тэдгээрийг барагдуулах хариуцлагыг хууль тогтоомжийн дагуу хүлээнэ.

44.Сургалтын төлбөрийн зээл авах хүсэлт гаргасан суралцагчийн талаар тодорхойлолт өгсөн тухайн шатны Засаг дарга тодорхойлолтынхоо үнэн зөвийг хариуцах бөгөөд тухайн суралцагчийг төгсөөд орон нутагтаа ажиллуулах, сургалтын төлбөрийг барагдуулахад хяналт тавина.

45.Суралцах хугацаандаа авсан зээлээ хүүгийн хамт тогтоосон хугацаанд төлөөгүй суралцагчдын төлбөрийг барагдуулах талаар Сургалтын төрийн сан зохих журмын дагуу шүүхэд хандана.

ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР ТОГТООХ ТУХАЙ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр
Улаанбаатар хот

Дугаар 61

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цэргийн албыг 2001 онд биеэр дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор тогтоосугай.
2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Батлан хамгаалахын сайд

Н.ЭНХБАЯР
Ж.ГҮРРАГЧАА

ЦЭРГИЙН АЛБЫГ 2001 ОНД БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААХ ИРГЭНИЙ ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Аймаг, нийслэлийн нэр	Тооны дээд хязгаар
1.	Архангай	120
2.	Баян-Өлгий	35
3.	Баянхонгор	120
4.	Булган	30
5.	Говь-Алтай	15
6.	Говьсүмбэр	20
7.	Дархан-Уул	35
8.	Дорноговь	30
9.	Дорнод	30
10.	Дундговь	16
11.	Завхан	30
12.	Орхон	15
13.	Өвөрхангай	80
14.	Өмнөговь	34
15.	Сүхбаатар	20
16.	Сэлэнгэ	30
17.	Төв	100
18.	Увс	60
19.	Ховд	60
20.	Хөвсгөл	35
21.	Хэнтий	30
22.	Улаанбаатар	55
	Дүн	1000

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ/ Гаалийн улсын байцаагчийн сахилгын тусгай дүрэм /

2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр
Улаанбаатар хот

Дугаар 13

Гаалийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гаалийн улсын байцаагчийн сахилгын тусгай дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 311 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, "Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 142 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Санхүү, эдийн засгийн сайд

Н.ЭНХБАЯР
Ч.УЛААН

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН САХИЛГЫН ТУСГАЙ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь гаалийн улсын байцаагчийн /цаашид "байцаагч" гэх/ сахилгын үндсэн агуулга, хэм хэмжээг тогтоож, түүнийг дагаж мөрдөх, сахин биелүүлэх, түүнд хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Байцаагчийн сахилгын үндсэн зарчим

2.1. Өргөсөн тангарагтаа үнэнч байж, хуулийг чанд сахин биелүүлж, бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зөрчлийг гаргуулахгүй байж, татвар, хураамжийг үнэн зөв ногдуулан улсын төсвийн орлого, улс орныхоо эдийн засгийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалан албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд шударгаар биелүүлнэ.

2.2. Авилгалаас ангид байж, хууль тогтоомж зөрсөн үйлдэлтэй тэмцэх, хуулийн хүрээнд хийгдэж байгаа худалдааг дэмжих, худалдааны шударга байдлыг хангахын төлөө ажиллана.

Гурав. Байцаагчийн сахилгын шаардлага

3.1. Улсын болон хувийн эрх ашиг зөрчилдөж болох аливаа нөхцөл байдалд орохоос цаг ямагт өөрийгөө сэргийлж, хууль тогтоомжид хориглохоор заасан болон дараахь үйлдэл гаргахыг хориглоно:

3.1.1. гаалийн хяналт, шалгалт, бүрдүүлэлт явуулахын өмнө болон явцад, түүнчлэн тухайн үед ажил үүрэг гүйцэтгээгүй байхдаа үйлчлүүлэгч байгууллага, иргэнтэй үгсэн тохирч татвар, хураамж болон зөрчлийг хөнгөлөх, нуун дарагдуулах;

3.1.2. гаалийн хяналт, шалгалт, бүрдүүлэлтийг дутуу хийж татвараас зайлсхийх, бараа, тээврийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлэх боломж бусдад олгох;

3.1.3. гаалийн хяналт, шалгалт, бүрдүүлэлтийг хийсний төлөө үйлчлүүлэгч байгууллага, иргэнээс барааг нь үнэгүй авах, хөнгөлөлттэй үнээр худалдан авах, үйлчлүүлэх, зээл, бэлэг дурсгалын зүйлс авах, өгөх, зуучлах, дэмжих, зөвлөх, тэдний зардлаар гадаад, дотоодод зорчих, байрлах, хоол, цайллаганд уригдах зэрэг хууль бус хангамж эдлэх;

3.1.4. гаалийн бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, үйлдэхэд оролцох, энэ талаар зөвлөлгөө, зааварчилга өгөх;

3.1.5. гаалийн байгууллагаас хийгдэх гэж байгаа хяналт, шалгалтын талаар шалгуулах байгууллага, иргэнд мэдэгдэх, гаалийн хяналт, шалгалтын нарийн нууц үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, стратеги, тактикийг задруулах;

3.1.6. гаалийн хяналт, шалгалт, бүрдүүлэлт, санхүүгийн үйл ажиллагаанд хөтлөгддөг баримт, маягтыг үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, хууль бусаар ашиглах;

3.1.7. албан тушаалаа ашиглан улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа болон бусад бараа, тээврийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлэх үүрэг хүлээх, нэвтрүүлэхэд оролцох;

3.1.8. албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээлэл, тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг ашиглах, хуурамч баримт бичиг, тодорхойлолт, баталгаа үйлдэх, тэмдгээ дарах, тэмдгээ ашиглах боломж бусдад олгох;

3.1.9. сэтгэц нөлөөт болон мансууруулах бодис хэрэглэх, ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэж байхдаа түүнчлэн дүрэмт хувцастай үедээ согтууруулах ундаа хэрэглэх.

3.2. Үйлчлүүлэгчдийг чирэгдүүлэх, хүнд суртал гаргахыг цээрлэнэ.

3.3. Өөрийн өмч, орлого, түүнд орсон өөрчлөлтийн талаар хууль тогтоомжид заасны дагуу мэдээлж байна.

3.4. Гаалиар үйлчлүүлдэг байгууллага, иргэнээр зуучлуулан эсвэл хууль бус баталгааны үндсэн дээр зээл авах, өр үүсгэх, өрөнд орох, мөрийтэй тоглоом тоглохыг цээрлэнэ.

3.5. Албан ёсны арга хэмжээ, хүлээн авалтад оролцох үедээ согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх, бусадтай зүй бусаар харьцах, дэг журам зөрчихийг цээрлэнэ.

Дөрөв. Байцаагчийн сахилгад тавих хяналт

4.1. Байцаагчийн сахилгад хяналт тавих, үнэлгээ өгөх, зөрчил гаргасан эсэхийг шалгаж тогтоох эрх, үүрэг бүхий Сахилгын хороо /цаашид "хороо" гэх/ Улсын гаалийн ерөнхий газарт ажиллана.

4.2. Хороог Улсын гаалийн ерөнхий газрын дарга байгуулна.

4.3. Гаалийн удирдах төв байгууллагын дэд дарга, хэлтсийн дарга, харьяа гаалийн газар, хороо, төв, албаны дарга өөрийн хариуцсан нэгжид ажилладаг байцаагчдын хууль тогтоомж, энэ дүрмийн биелэлтэд өдөр тутмын хяналт тавьж, зөрчсөн тохиолдолд үндэслэл, саналаа баримт материалын хамт Хороонд ирүүлнэ.

4.4. Хороо нь зөрчил, баримт материалыг шалгах ажиллагааг явуулж, дараахь дүгнэлтийг гаргана:

4.4.1. тухайн зөрчлийг хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоон, шаардлагатай бол хууль хяналтын холбогдох байгууллагад шилжүүлж шалгуулах;

4.4.2. баримт, материалыг дахин шалгуулах, нэмэлт баримт материал бүрдүүлэхээр буцаах, шаардлагатай гэж үзвэл тодорхой албан тушаалтныг томилж шалгуулах;

4.4.3. байцаагчийн албан тушаал, эрхийг хуульд заасан үндэслэл, тодорхой баримтын үндсэн дээр түдгэлзүүлэх тухай санал гаргах;

4.4.4. зөрчил нь нотлогдож эрүүгийн хариуцлага хүлээхээс бусад тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах;

4.4.5. зөрчил нь нотлогдоогүй тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах тухай саналыг хэрэгсэхгүй болгох, зөрчил гаргаагүй гэж үзэх.

4.5. Хороо нь шаардлагатай гэж үзвэл нэмэлт материалыг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авна.

4.6. Хороо нь иргэдийн өргөдөл, гомдол, мэдээлэл, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн шүүмжлэлээр болон удирдлагын санаачилгаар хууль тогтоомж, өргөсөн тангараг, энэ дүрмийг зөрчсөн үндэслэлийг шалгана.

4.7. Хороо нь хууль тогтоомж, энэхүү дүрмийг зөрчсөн эсэхийг шалган тогтоох ажиллагааг явуулахдаа дараахь үүргийг хүлээнэ:

4.7.1. байцаагчийн гаргасан зөрчилд холбогдох нотлох баримтыг бүрэн бүрдүүлсэн байх;

4.7.2. хорооны үйл ажиллагаа, дүгнэлт нь хуульд нийцсэн, шударга ёс, тэгш байдлыг хангасан байх;

4.7.3. сахилгын талаар нэгдсэн дүгнэлт гаргах.

4.8. Зөрчилд холбогдогч нь баримт материалтай танилцах, нэмэлт тайлбар хийх, дахин шалгаж тодруулахыг шаардах эрхтэй ба энэ тухай албан ёсоор тавина.

Тав. Сахилгын шийтгэл ногдуулах

5.1. Хууль тогтоомж, өргөсөн тангараг, энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн байцаагчийн үйлдэл, эс үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай болон Гаалийн тухай хуульд заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна.

5.2. Хууль тогтоомж болон энэ дүрмийн Гурвын 1-д хориглохоор заасныг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл нь гаалийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

5.3. Сахилгын шийтгэл ногдуулах тухай Улсын гаалийн ерөнхий газрын даргын тушаал гарна.

5.4. Сахилгын шийтгэл ногдуулах тухай тушаалыг сахилгын шийтгэл хүлээсэн байцаагчид танилцуулж, гарын үсэг зуруулан хувийн хэрэгт хавсаргах бөгөөд шаардлагатай гэж үзвэл байгууллагын хамт олонд мэдээлнэ.

5.5. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар /өвчтэй, ээлжийн амралт, чөлөөтэй байсан түүнчлэн зөрчил гаргасан байдлыг шалгасан хугацааг энэ хугацаанд оруулахгүй/, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй. Төрийн эрх бүхий байгууллагын хяналт шалгалт, гаалийн бүрдүүлэлтийн дараахь шалгалтаар илэрсэн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулахад энэ хугацааг баримтлахгүй.

5.6. Сахилгын нэг зөрчилд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ногдуулж болохгүй.

5.7. Байцаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

5.8. Сахилгын шийтгэлийн талаар Төрийн албаны зөвлөл болон шүүхэд гомдол гаргасан нь түүнийг биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

Зургаа. Бусад

6.1. Гаалийн албанаас халах, эрхийг хасах сахилгын шийтгэл хүлээсэн, эрх нь түдгэлзсэн байцаагч нь хувийн дугаар бүхий тэмдэг, энгэрийн тэмдэг, үнэмлэх, тооцоот хуудас, дүрэмт хувцасны тооцоог ажлын 5 хоногт багтаан хийж дуусгасан байна.

6.2. Байцаагчид гаалийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулах нь төрийн албанаас чөлөөлөх, гаалийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.3. Албан тушаалыг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах сахилгын шийтгэлийг Гаалийн улсын ахлах байцаагч түүнээс дээш албан тушаал эрхэлж буй байцаагчид ногдуулна.

6.4. Гаалийн улсын байцаагчийн эрхийг хасах сахилгын шийтгэлийн дээд хугацаа нь 1 жил хүртэл байна. Сахилгын шийтгэлийн хугацаа дуусахад байцаагч нь гаалийн мэргэшлийн шалгалт өгч, тэнцсэн тохиолдолд эрхийг сэргээнэ.

6.5. Гаалийн байгууллагад туршилтын хугацаагаар ажиллаж буй шалгагчид энэ дүрэм мөн адил үйлчилнэ.

---oO---

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЖУРАМ, ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ /Ой, хээрийн түймрийн үед хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах журам, Ой, хээрийн түймрийг унтраах ажилд оролцож буй иргэдийн хангамж, тэдгээрийн заавал эзэмшсэн байх зүйлийн жагсаалт/
1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр
Улаанбаатар хот

Дугаар 107

Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Ой, хээрийн түймрийн үед хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах журам"-ыг 1 дүгээр хавсралтын, "Ой, хээрийн түймрийг унтраах ажилд оролцож буй иргэдийн хангамж, тэдгээрийн заавал эзэмшсэн байх зүйлийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Батлан хамгаалах яамны сайд

М.ЭНХСАЙХАН
Д.ДОРЛИГЖАВ

ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ҮЕД ХҮН ХҮЧ, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДАЙЧИЛГАА ЗАРЛАХ, ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмыг ой, хээрийн түймэртэй тэмцэх ажилд хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах /цаашид "дайчилгаа зарлах, явуулах" гэнэ/-д дагаж мөрдөнө.

2. Энэ журмыг аж ахуйн нэгж, байгууллага нь харьяалал болон өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мөрдөнө.

Хоёр. Ой, хээрийн түймрийн үед хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах тухай шийдвэр гаргах

3. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн түймрийг унтраахад оролцох хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах шийдвэрийг дараахь байдлаар гаргана:

а/нутаг дэвсгэртээ гарсан түймрийг шуурхай унтраах ажлыг зохион байгуулахаар иргэд, тээврийн болон багаж хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах шийдвэрийг баг, хорооны Засаг дарга;

б/баг, хороодын нутаг дэвсгэрийг дамжин тархсан, тэдний хүчээр унтраах боломжгүй түймэртэй тэмцэх ажилд сум, дүүргээсээ нэмэлт хүч, техник хэрэгсэл гаргахаар дайчилгаа зарлах, явуулах шийдвэрийг сум, дүүргийн Засаг дарга;

в/сум, дүүргийн нутаг дэвсгэрийг дамжин тархсан, орон нутгийн хүчээр унтраах боломжгүй түймэртэй тэмцэх үед аймаг, нийслэлээс нэмэлт хүн хүч, техник хэрэгсэл гаргахаар дайчилгаа зарлах, явуулах шийдвэрийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга;

г/улсын хил, аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дамжин тархсан бөгөөд орон нутгийн хүчээр унтраах боломжгүй түймэртэй тэмцэх ажилд зохион байгуулалттай болон бусад хүн хүч, техник хэрэгсэл гаргахаар дайчилгаа зарлах, явуулах шийдвэрийг Засгийн газар.

4. Энэ журмын 3 дугаар зүйлийн "а"-д заасан шийдвэр гаргах үндэслэл нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдээс ирүүлсэн бодит мэдээлэл, мөн зүйлийн "б, в, г"-д заасан шийдвэрийг гаргах үндэслэл нь сум, аймаг, нийслэлийн байнгын онцгой комисс болон Улсын байнгын онцгой комиссын санал, дүгнэлт байна.

5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн байнгын онцгой комисс санал, дүгнэлтээ дараахь байдлаар гаргана:

а/тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэр дэх түймрийн тархалтын байдал, байршил, баг, хорооноос голомтод ажиллаж байгаа хүн хүч, техник хэрэгслийн тоо, нэмж дайчлагдах хүч, хэрэгслийн тооцоо;

б/тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тархсан буюу төр, иргэдийн өмч болон байгаль орчинд үлэмж хэмжээний хор хөнөөл учруулж болзошгүй түймрийн цагийн байдал, хохирол, сум, дүүргээс дайчлагдан ажиллаж байгаа хүн хүч, техник хэрэгслийн тухай танилцуулга, түймрийн байршил, тархалтыг харуулсан тойм зураг, дайчилгаа зарлах аж ахуйн нэгж, байгууллагын нэр, тэдгээрээс дайчлан гаргах хүн хүч, техник хэрэгслийн тооцоо.

6. Улсын байнгын онцгой комисс санал, дүгнэлтээ дараахь байдлаар гаргана:

а/аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрээр дамжин тархсан буюу бүс нутгийг хамарсан түймрийн цагийн байдал, тархалт, учруулсан хохирол, ажиллаж байгаа хүч хэрэгслийн тухай танилцуулга;

б/түймрийн байршил, тархалтын байдлыг харуулсан газрын зураг;

в/дайчилгаа зарлах аж ахуйн нэгж, байгууллагын нэр, тэдгээрээс дайчлан гаргах хүн хүч, техник хэрэгслийн тооцоо;

г/Засгийн газрын шийдвэрийн төсөл, түүнийг Засгийн газрын хуралдаанд оруулах тухай Улсын байнгын онцгой комиссоос гаргасан шийдвэр;

Нийтлэгдсэн: "Засгийн газрын мэдээлэл" сэтгүүл 1997 он, № 4, 309-315 дахь талд

д/иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр.

Гурав. Дайчилгаа зарлах

7.Ой, хээрийн түймрийн үед хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа явуулах тухай зарлан мэдээлэх бүдүүвчийг баг, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн болон Улсын иргэний хамгаалалтын төлөвлөгөөнд тусган мөрдөх бөгөөд түүнд жил тутам тодотгол хийж байна.

8.Ой, хээрийн түймэртэй тэмцэх хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа явуулах тухай зарыг дор дурдсанаар зарлан мэдээлнэ:

а/баг, хорооны Засаг дарга нь түймрийн голомт илэрсэн нутаг дэвсгэрийн иргэдэд эхний ээлжинд шуурхай мэдэгдэж, улмаар бусад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад зарлах ажлыг тогтсон бүдүүвчийн дагуу зохион байгуулах замаар;

б/сум, дүүргийн Засаг дарга нь баг, хорооны Засаг дарга, нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчдад мэдэгдэх замаар;

в/аймаг, нийслэлийн Засаг дарга нь холбогдох сум, дүүргийн Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчдад мэдэгдэх замаар;

г/Улсын байнгын онцгой комисс нь холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригчдад мэдэгдэх замаар.

9.Ой, хээрийн түймэртэй тэмцэх ажилд хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа явуулах тухай зарлан мэдээлэхэд бүх төрлийн мэдээллийн хэрэгслийг төлбөргүйгээр ашиглах эрхийг зохих шатны Засаг дарга. Улсын байнгын онцгой комисс эдэлнэ.

10.Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга, Улсын байнгын онцгой комиссоос түймэртэй тэмцэх дайчилгаа явуулах тухай зарлан мэдээлэхдээ түймрийн голомтын байршил, дайчлагдах хүн хүч, техник хэрэгслийн тоо, зохион байгуулалт, хангах бэлтгэл, гүйцэтгэх үүрэг, ажиллах, цугларах газар /байр/, хугацааг тодорхой зааж өгнө.

Дөрөв. Дайчилгаа явуулах

11.Түймэртэй тэмцэх ажилд оролцох хүн хүч, техник хэрэгслийн дайчилгааг иргэний хамгаалалтын тухайн шатны төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

12.Дайчилгааны хүн хүч, техник хэрэгслийг дор дурдсанаар бүрдүүлнэ:

а/баг, хороо, сум, дүүрэг нь нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсад, техник хэрэгсэл, оршин суугчдаас дайчлах замаар;

б/аймаг, нийслэл нь түймрийн голомт бүхий болон бусад сум, дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсад, техник хэрэгсэл, оршин суугчдаас дайчлах замаар;

в/Улсын байнгын онцгой комисс нь цэрэг, цагдаа, хорих зэрэг байгууллагын зохион байгуулалттай хүн хүч, техник хэрэгслийг болон иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, аймаг, нийслэл, бүс нутгийн хүн хүч, техник хэрэгслийг дайчлах замаар.

13.Бүх шатны Засаг дарга шаардлагатай гэж үзвэл нутаг дэвсгэртээ түр байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, түр оршин суугчид, түүнчлэн зорчин явагчдыг харьяалал харгалзахгүйгээр түймэртэй тэмцэх дайчилгаанд хамруулж болно.

14.Бүх шатны Засаг дарга, байнгын онцгой комисс дайчлагдсан хүн хүч, техник хэрэгслийг зохион байгуулах, хуваарилах ажлыг эрхлэн гүйцэтгэж, тэдгээрийн бүртгэлийг хөтөлнө.

15.Бүх шатны Засаг дарга өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт байрлаж байгаа зохион байгуулалттай хүч хэрэгсэл /цэргийн болон хорих анги, салбар/-ийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр түймэр унтраах ажилд дайчилж болно.

16.Түймэр унтраах ажилд Монгол улсын харьяат, хөдөлмөрийн чадвартай, 16-60 хүртэлх насны эрэгтэй, 16-55 хүртэлх насны эмэгтэй иргэдийг дайчлан оролцуулна. Жирэмсэн эмэгтэй, асрамжлах хүнгүй сургуулийн өмнөх насны хүүхдийн асран хамгаалагч, эмнэлэг, эрчим хүч, холбооны байгууллагын ээлжийн ажилчид, холбогдох хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр дайчлахыг хориглосон хүмүүст энэ заалт хамаарахгүй.

17.Түймэрт дайчлагдах хүн хүч, техник хэрэгслийн тоо хэмжээг тухайн түймрийн тархалт, төлөв байдал, учруулж болохуйц хохирол зэргээс хамааран тогтооно.

18.Түймрийг унтраах хүн хүч, техник хэрэгслийн дайчилгааг шуурхай явуулах ажлыг тухайн шатны байнгын онцгой комисс хариуцан зохион байгуулна.

Тав.Бусад зүйл

19.Түймэртэй тэмцэх ажилд дайчлагдсан иргэдийг хоол хүнс, тээврийн хэрэгсэл, багаж шатахуунаар хангах асуудлыг дайчилгаа зохион байгуулж байгаа тухайн шатны Засаг дарга хариуцах бөгөөд холбогдох зардлыг орон нутгийн төсвөөс гаргана.

20.Түймрийн хор уршиг, хөнөөл ихэссэн үед энэ журмын 3 дугаар зүйлийн "г"-д заасны дагуу дайчилгаа явуулахад гарсан зардлыг Засгийн газраас гаргана.

21.Ой, хээрийн түймэрт дайчилгаагаар ажилласан иргэний эрхэлж байсан ажил, албан тушаалыг үндсэн аж ахуйн нэгж, байгууллага хэвээр хадгалж, дундаж цалинг олгоно.

22.Ажил эрхлээгүй иргэдийг түймэрт дайчилсан нөхцөлд мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлан тэдэнд хөлсийг ажилласан цагаар нь тооцон сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.

23.Ой, хээрийн түймэрт улсын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн техник хэрэгслийг дайчлан ажиллуулах үеийн шууд зардлыг зах зээлийн жишиг, үнийн дагуу тухайн шатны Засаг дарга хариуцан олгоно.

---oOo---

ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙГ УНТРААХ АЖИЛД ОРОЛЦОЖ БУЙ ИРГЭДИЙН ХАНГАМЖ, ТЭДГЭЭРИЙН ЗААВАЛ ЭЗЭМШСЭН БАЙХ ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

I.Түймрийг унтраах ажилд оролцож буй иргэдийн хангамж

- 1.Түймэр унтраах ажилд оролцогч иргэн бүр дараахь багаж хэрэгсэл, хувцсыг бэлтгэсэн байна:
а/троссон шүүр буюу резинэн цохиур;
б/даавуун материалаар хийгдсэн хөнгөн, дулаан хувцас, ажлын гутал, ахуйн хэрэглээний зүйлс;
в/бэртэлт, түлэгдэлтийн үед хэрэглэх түрхлэг, ороож боох материал, эм..

II.Түймрийг унтраах ажилд оролцож буй иргэдийн заавал эзэмшсэн байвал зохих зүйлүүд

- 1.Түймэр унтраах энгийн болон механик багаж хэрэгслийг хэрэглэх, ажиллуулах чадвар, дадлага;;
2.Түймэр унтраах арга;;
3.Түймрийг унтраах үед ажиллах, авч хэрэгжүүлэх аюулгүй ажиллагааны заавар;;
4.Түймрийн үед түлэгдэн гэмтэж, бэртсэн хүмүүст эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадвар.

Тайлбар: Энэ жагсаалтын II-т заасан ур чадвар, аргыг эзэмшүүлэх, зааварчилгаа өгөх ажлыг жил бүрийн I улиралд багтаан тухайн шатны Засаг дарга, мэргэжлийн байгууллага зохион байгуулан хэрэгжүүлнэ.

---oOo---

